



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН СУДЛААЧИД ДҮГНЭСЭН НЬ

ШИНЭ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ СУМЫН ТҮВШИНД

Шинэ Эрүүгийн хууль,
тогтоомжийн хэрэгжилт


Гэр бүлийн хүчирхийлэл
үйлдэх зөрчил, гэмт
хэргийн шийдвэрлэлт



ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН СУДЛААЧИД ДҮГНЭСЭН НЬ

Улаанбаатар хот
2021

ННА 67.408
ДАА 345
Э-807



ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН СУДЛААЧИД ДҮГНЭСЭН НЬ

ШИНЭ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ СУМЫН ТҮВШИНД
Судлаачид: З.ГАНЧИМЭГ, Б.ЧИМЭДЛХАМ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙН
ШИЙДВЭРЛЭЛТ, ЯЛ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛ ОРОН НУТАГТ
Судлаачид: Ж.САРУУЛ, Л.ОЮУНЦЭЦЭГ, Ж.ЦЭЦЭГМАА

Тус тайлангийн үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9742-0-6

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум нь 2017 оны 7 дугаар сарын 1-ээс мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шинэчлэлийг гүнзгийрүүлэх чиглэлээр санал зөвлөмж боловсруулахад байнга анхаарч ажиллаж байгаа билээ.

Энэ удаад шинэ Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд авч судалсан хоёр бодлогын судалгааг нэгтгэн Та бүхэнд толилуулж байна. Монгол Улсын тухайд өргөн уудам нутаг дэвсгэртэй, дэд бүтэц сул хөгжсөн нь аливаа хууль тогтоомж нэг мөр хэрэгжихэд тодорхой хүндрэл учруулдаг тул тулгарч буй асуудлыг тодорхойлох, шийдэх арга замыг эрэлхийлэхэд энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ач холбогдол их юм. Нөгөө талаас, орон нутагт ажиллаж буй мэргэжилтнүүд, төрийн бус байгууллага тус судалгааг гүйцэтгэсэн нь өөрийн орон нутагт тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд тэдний оролцоог хангахад ач холбогдолтой хэмээн бид үзсэн билээ.

Тус тайланд судлаач З.Ганчимэг, Б.Чимэдлхам нарын “Шинэ эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт сумын түвшинд”, судлаач Ж.Саруул, Л.Оюунцэцэг, Ж.Цэцэгмаа нарын “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй байдал орон нутагт” сэдэвт судалгаанууд багтсан болно.

Манай улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг Нээлттэй Нийгэм Форум зорьж ирсэн бөгөөд энэ хүрээнд 20 орчим судалгаа, мониторингийн тайлан олны хүртээл болсныг дурдахад таатай байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П. Эрдэнэжаргал

АГУУЛГА

ШИНЭ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ СУМЫН ТҮВШИНД	5-42
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ, ЯЛ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛ ОРОН НУТАГТ	43-78

ШИНЭ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ СУМЫН ТҮВШИНД

Судлаачид: З.ГАНЧИМЭГ, Б.ЧИМЭДЛХАМ

ГАРЧИГ

УДИРТГАЛ	8
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	10
НЭГ. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ СУМЫН ТҮВШИНД	12
1.1. Сум дундын шүүхээр хянан шийдвэрлэгдсэн гэмт хэргийн төрөл, онцлог, оногдуулж буй ял шийтгэл, хохирол	12
1.1.1 Дундговь аймгийн Сайнцагаан сум	12
1.1.2 Өмнөговь аймгийн Ханбогд сум	14
1.1.3 Увс аймгийн Улаангом сум	16
1.1.4 Хэнтий аймгийн Бор-Өндөр сум	19
1.2. Эрүүгийн хуулийн үр нөлөө суманд	21
ХОЁР. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨ СУМЫН ТҮВШИНД	27
2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төрөл, удирдлага зохион байгуулалт	27
2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал, үр нөлөө	28
2.2.1 Төлөвлөлтийн үр нөлөө	29
2.2.2 Тайлагнал, хяналтын үр нөлөө	34
ДҮГНЭЛТ	37
ЗӨВЛӨМЖ	39
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	40

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

УДИРТГАЛ

Эрүүгийн хууль нь хүний амь нас, эрүүл мэнд, нэр төр, эд хөрөнгө, улс орны аюулгүй байдал, язгуур эрх ашиг, үнэт зүйлсийг гэмт халдлагаас хамгаалах онцгой хамгаалалт болохын хувьд хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн, урт хугацаанд тогтвортой үйлчлэх чадамжтай байх нь зүй ёсны шаардлага бөгөөд энэ зорилтын хүрээнд манай улс 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын зорилтыг хууль тогтоогч, эрдэмтэн судлаачид тодорхойлохдоо өмнөх хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад чиглэсэн, нийгмийн бодит амьдралд нийцсэн, ялын бодлогыг хэрэгжүүлэхэд болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах, гэмт хэргийн гаралтыг ихэсгэхгүй байх буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэгдсэн зохицуулалт бүхий, энэрэнгүй, хийдэлгүй байх зэрэг “олон талт” шалгуур, шаардлагыг хангасан байх ёстой¹ гэж дүгнэж байжээ. Уг хууль дээрх шаардлагыг хангасан эсэх нь хуулийн ерөнхий үзэл баримтлал бодит амьдралд хэрэгжиж, хэрэглэгдэж байгаа эсэхээр тодорхой болно. Энэ судалгааг 2015 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг засаг захиргааны анхан шатны нэгж болох сумын түвшинд хийж гүйцэтгэлээ.

Сум дундын шүүхээр хянан шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн тоо, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, гэмт хэрэгт холбогдогсод болон хохирогчид, шүүхээр ял шийтгүүлсэн этгээдийн тоо зэрэг нь тухайн сумын нийгэм, эдийн засаг, ажиллах хүчин, хүн ам зүйн бүтцэд шууд болон шууд бусаар нөлөөлөл үзүүлдэг.

¹ Хуульч Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган “Эрүүгийн хуучин ба шинэ хуулийн зөрлөгт үүссэн ээдрээ, эмгэг, эсрэгцэл” нийтлэл, <http://gan-baatar.blogspot.com/2017/08/blog-post.htm> 2017 оны 8 дугаар сарын 3

Суманд гарч буй гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлахдаа дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Сумын түвшинд эрүүгийн хуулийн хэрэгжилт;
- Сумын түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.

Судалгааны дүнд Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн явц, хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, сумын түвшинд гарч байгаа эерэг, сөрөг нөлөөлөл, эрүүгийн хуулийн шинэчлэл анх тавьсан зорилгодоо хүрч байгаа эсэхэд үнэлгээ өгөх, мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг сумын түвшинд үнэлж, холбогдох санал, зөвлөмж боловсруулсан болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгж болох 330 сумаас судалгаанд хамруулах сумыг түүвэрлэн сонгохдоо газарзүйн байршил, хүн амын тоо, ажил эрхлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан үзлээ. Үүнд:

- Сонгосон сумдын гэмт хэргийн гаралтын түвшин;
- Сум дундын шүүхийн байршил;
- Судалгаанд шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийн ил тод байдал, олдоц, эх сурвалжийн найдвартай байдал зэрэг болно.

Дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу Увс аймгийн Улаангом, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дундговь аймгийн Сайнцагаан, Өмнөговь аймгийн Ханбогд сумыг тус тус сонгож судалгаанд хамрууллаа.

Хүснэгт 1. Сонгосон сумдын 2017-2019 оны тоон мэдээлэл, өссөн дүнгээр

Аймаг/ сумын нэр	Хүн амын тоо		Шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тоо		Гэмт хэргийн гаралтын түвшин (аймгийн хэмжээнд)	Сум дундын шүүх байрладаг эсэх
	Айм-гийн	Сумын	Аймгийн хэм-жээнд	Сумын хэм-жээнд		
Увс/ Улаангом	82,946	31,687	523	261	13%	Тийм
Хэнтий/ Бор-Өндөр	76,700	8,833	154	77	54.8%	Тийм
Дундговь/ Сайнцагаан	46,437	15,716	286	143	42%	Тийм
Өмнөговь/ Ханбогд	69,902	5,344	380	190	29%	Тийм

Эх сурвалж: www.1212.mn, Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном, 2018-2019 он

Судалгааны төсөлд өөр сумдыг хамруулахаар төлөвлөж байсан ч шаардлагатай мэдээллийн олдоц, эх сурвалжийн найдвартай байдал зэрэг нь судалгааны үр дүнд шууд нөлөөлөхөөр байсан тул зарим сумдыг өөрчилсөн болно. Судалгаа хийх явцад сум дундын шүүхээр хянан шийдвэрлэгдсэн гэмт хэргийн талаарх статистик тоо, мэдээлэл харьцангуй ил тод байв. Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр нөлөөний тайлан зэрэг мэдээллийг олоход хүндрэлтэй байлаа. Тухайлбал, хариуцсан байгууллагын цахим хуудас ажиллахгүй байх, ажиллаж байгаа нь сүүлийн 2-3 жилд мэдээллийн шинэчлэлт хийгдээгүй байх зэрэг хүндрэлүүд гарч байв.

Судалгааны тайланг холбогдох хууль тогтоомж, статистик тоо баримт, мэдээллийн эх сурвалжид тулгуурлан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших 3 жил буюу 2017-2019 оныг хамруулан бэлтгэлээ. Үүнд:

- Суманд гарсан гэмт хэргийн төрөл, оногдуулж буй ял шийтгэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх мэдээллийг шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн тоо баримтад үндэслэн дүн шинжилгээ хийв.
- Шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн дүн шинжилгээнд тулгуурлан өмнөх болон шинэ Эрүүгийн хуулийн зорилт сумын түвшинд хэрхэн хэрэгжиж байгаад харьцуулсан дүгнэлт хийлээ.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай (1997) болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай (2019) хуулиудыг харьцуулан судалж, сумын түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, түүний үр дүнг хуулийн зохицуулалтын хүрээнд төлөвлөлт-тайлагнал-хяналт шинжилгээний үе шатуудыг хамруулан дүн шинжилгээ хийсэн болно.
- Судалгааны явцад гүйцэтгэсэн ажлуудын үр дүнг бататгах зорилгоор холбогдох албан тушаалтнуудтай фокус бүлгийн ярилцлага зохион байгууллаа.

НЭГ. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ СУМЫН ТҮВШИНД

1.1. Сум дундын шүүхээр хянан шийдвэрлэгдсэн гэмт хэргийн төрөл, онцлог, оногдуулж буй ял шийтгэл, хохирол

Сумын түвшинд гарч буй гэмт хэргийн төрөл, онцлог, шалтгаан нөхцөл, оногдуулж буй ял шийтгэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх мэдээллийг сонгосон сумдын шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн тоо баримтад үндэслэн судаллаа. Үүнд:


1.1.1 Дундговь аймгийн Сайнцагаан сум



Тус аймаг 15 сумтай бөгөөд аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралтын түвшнээр² Сайнцагаан сум хамгийн өндөр буюу 42 орчим хувьтай байна. Шинэ Эрүүгийн хууль үйлчилж эхэлснээс хойш нийт 143 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс хүнийг алах гэмт хэрэг 3 буюу 2.9 хувь, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 50 буюу 34.9 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 43 буюу 30.06 хувь, хүчиндэх гэмт хэрэг 4 буюу 2.79 хувь, хулгайлах гэмт хэрэг 31 буюу 21.6 хувь, авто тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 12 буюу 8.3 хувийг тус тус эзэлж байна.

² Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном 2018 УБ., 2019 он 247-р тал

График 1. Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн тоон мэдээлэл (оноор)



Ял оногдуулалтын хувьд авч үзвэл, 75 хэрэг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 52.4 хувьд торгох, 15 хэрэг буюу 10.4 хувьд нийтэд тустай ажил хийлгэх, 32 хэрэг буюу 22.3 хувьд хорих ял тус тус оногдуулсан ба үүнээс 24 хэрэг буюу 16.7 хувь нь хорих ялыг биечлэн эдэлсэн байна. Харин 20 хэрэг буюу 13.9 хувьд нь хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн байх бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6 дугаар зүйлийн 6.7-д зааснаар хөнгөрүүлж хорих ял оногдуулсан 3 хэрэг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 2.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. 2017-2019 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлөлт, хувиар

Он	Хохирлын хэмжээ (сая.төг)	Нөхөн төлөлтийн хэмжээ (сая.төг)	Нөхөн төлөгдсөн хохирол (хувиар)
2017	155.4	61.7	39%
2018	182.0	90.7	49.8 %
2019	176.3	168.2	95.4%

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд, тус суманд хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийн гаралт хамгийн өндөр буюу нийт гэмт хэргийн 34.9 хувийг, шүүхээс оногдуулж буй ял шийтгэлийн 54.4 хувийг дангаараа эзэлж байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтын хэмжээ өссөн үзүүлэлттэй байгаа нь шүүхээр хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ихэссэнтэй холбоотой. Гэмт хэргийн төрлөөр авч үзвэл, харьцангуй хөнгөн төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг ажээ. Хэрэг шүүхээр шийдвэрлэгдэх үеэр шүүгдэгч, хохирогч эвлэрч, хохирлоо нөхөн төлөх нь нийтлэг байдаг байна.³

1.1.2 Өмнөговь аймгийн Ханбогд сум



Өмнөговь аймаг 15 сумтай бөгөөд аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралтын түвшнээр⁴ Ханбогд сум хамгийн өндөр буюу 29 орчим хувьтай байна. 2017-2019 онд нийт 190 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс хүнийг алах гэмт хэрэг 4 буюу 2.1 хувь, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 50 буюу 26.3 хувь, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 43 буюу 22.6 хувь, хүчиндэх гэмт хэрэг 5 буюу 2.63 хувь, хулгайлах гэмт хэрэг 33 буюу 17.3

³ Судалгааны багийн зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс

⁴ Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном 2018 УБ., 2019 он 247-р тал

хувь, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг 14 буюу 7.3 хувь, Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэг 3 буюу 1.5 хувь, авто тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 26 буюу 13.6 хувийг тус тус эзэлж байна.

График 2. Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн тоон мэдээлэл (оноор)



Ял оногдуулалтын байдлыг авч үзвэл, 130 хэрэг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 68.4 хувьд торгох, 3 хэрэг буюу 1.5 хувьд нийтэд тустай ажил хийлгэх, 22 хэрэг буюу 11.5 хувьд хорих ял тус тус оногдуулсан ба үүнээс 20 хэрэг буюу 10.5 хувь нь хорих ялыг биечлэн эдэлжээ.

Хүснэгт 3. 2017-2019 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлөлт, хувиар

Он	Хохирлын хэмжээ (сая.төг)	Нөхөн төлөлтийн хэмжээ (сая.төг)	Нөхөн төлөгдсөн хохирол (хувиар)
2017	106.3	67.6	63.6%
2018	1,119.9	322.2	28.7%
2019	467.0	419.3	89.7%

Харин 35 хэрэг буюу 18.4 хувьд нь хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн байх бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6 дугаар зүйлийн 6.7-д зааснаар хөнгөрүүлж хорих ял оногдуулсан 26 хэрэг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 13.6 хувийг эзэлж байна.

Тус суманд хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийн гаралт хамгийн өндөр буюу нийт гэмт хэргийн 26.3 хувийг эзэлж байгаа бол шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ялыг хамгийн өндөр хувиар оногдуулжээ. Түүнчлэн Ханбогд суманд үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлөөс хамаарч хохирол нөхөн төлөлтийн хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын эсрэг гэмт хэрэг хохирол өндөртэй, гэм буруутай этгээд нас барах, хөдөлмөрийн чадвар алдах нь их байдгаас шалтгаалан хохирлын нөхөн төлөлт харилцан адилгүй байдаг байна.⁵

1.1.3 Увс аймгийн Улаангом сум




Тус аймаг 19 сумтай бөгөөд аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралтын түвшнээр⁶ Улаангом хоёрдугаарт буюу 13.1 орчим хувьтай байна. 2017-2019 онд нийт 261 хэрэг шүүхээр

⁵ Судалгааны багийн зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс

⁶ Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном 2018 УБ., 2019 он 247-р тал

шийдвэрлэгдсэнээс хүнийг алах гэмт хэрэг 2 буюу 0.76 хувь, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 20 буюу 7.6 хувь, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 114 буюу 43.6 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 30 буюу 11.4 хувь, хүчиндэх гэмт хэрэг 16 буюу 6.1 хувь, бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох гэмт хэрэг 2 буюу 0.7 хувь, хулгайлах гэмт хэрэг

График 3. Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн тоон мэдээлэл (оноор)



54 буюу 20.6 хувь, нотлох баримтыг хуурамчаар үйлдэх устгах гэмт хэрэг 4 буюу 1.5 хувь, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг 7 буюу 2.6 хувь, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 7 буюу 2.6 хувь, авто тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 15 буюу 5.7 хувийг тус тус эзэлж байна.

Ял оногдуулалтыг авч үзвэл, 261 эрүүгийн хэргийн 109 буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 41.7 хувьд нь торгох, 51 хэрэг буюу 19.5 хувьд нийтэд тустай ажил хийлгэх, 61 хэрэг буюу 23.3 хувьд хорих ял тус тус оногдуулжээ. Үүнээс 59 хэрэг буюу 22.6 хувь нь хорих ялыг биечлэн эдэлжээ.

Хүснэгт 4. 2017-2019 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлөлт, хувиар

Он	Хохирлын хэмжээ (сая.төг)	Нөхөн төлөлтийн хэмжээ (сая.төг)	Нөхөн төлөгдсөн хохирол (хувиар)
2017	25.5	0.1	0.4%
2018	83.2	28.7	34.5%
2019	169.8	30.4	17.9%

Харин 40 хэрэг буюу 15.3 хувьд хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн байх бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6 дугаар зүйлийн 6.7 дугаар зүйлд зааснаар хөнгөрүүлж хорих ял оногдуулсан байх ба энэ нь 7 хэрэг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 1.3 хувийг эзэлж байна.

Улаангом нь хүн ам ихээр төвлөрсөн аймгийн төвийн сум тул судалгаанд хамруулсан бусад сумтай харьцуулахад гэмт хэргийн гаралт хамгийн өндөр, мөн хэргийн төрөл нь ч харьцангуй олон байна. Гэхдээ голчлон хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэл нийт гэмт хэргийн 34.8 хувийг эзэлж байгаа юм. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралт хоёрт бичигдэж байгаагаас малын хулгайн гэмт хэрэг цөөнгүй гарч, нийт шийдвэрлэсэн хэргийн 20.6 хувийг эзэлжээ. Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ялыг түлхүү оногдуулсан байна.

Түүнчлэн тус сумын хувьд хохирол нөхөн төлөлтийн хувь хэмжээ сонгосон сумдаас хамгийн бага байгаа нь анхаарал татсан бөгөөд

шалтгаан нь гэмт хэргийн төрөл олон, учирсан хохирол өндөр, хохирлыг шүүхээр хэлэлцэхгүй орхих тохиолдол нэлээд хувийг эзэлдэг. Өөрөөр хэлбэл хохирогч, иргэний нэхэмжлэгч нь ихэвчлэн баримт бүрдүүлж өгдөггүй, хохирлоо нэхэмжлэхгүй байгаагаас хохирол нөхөн төлөлт бага байна гэж үзлээ.⁷

1.1.4 Хэнтий аймгийн Бор-Өндөр сум



Хэнтий аймаг 19 сумтай бөгөөд аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралтын түвшнээр⁸ Бор-Өндөр⁹ хамгийн өндөр буюу 54.8 орчим хувьтай байна. 2017-2019 онд нийт 77 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс хүнийг алах гэмт хэрэг 2 буюу 2.5 хувь, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 30 буюу 38.9 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 9 буюу 11.6 хувь, хүчиндэх гэмт хэрэг 6 буюу 7.7 хувь, хулгайлах гэмт хэрэг 23 буюу 30.8 хувь, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг 2 буюу 2.5 хувь, авто тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 5 буюу 6.4 хувийг тус тус эзэлж байна.

⁷ Судалгааны багийн зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс

⁸ Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном 2018 УБ., 2019 он 247-р тал

⁹ Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын хүн амын тоо болон шүүхийн харьяаллыг Хавсралт 1-ээс дэлгэрүүлж үзнэ үү.

График 4. Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн тоон мэдээлэл (оноор)



2017-2019 онд шүүхээр шийдвэрлэсэн нийт 77 эрүүгийн хэргийн 45 нь буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 58.4 хувьд торгох, 7 хэрэг буюу 9.9 хувьд нийтэд тустай ажил хийлгэх, 17 хэрэг буюу 22.0 хувьд хорих ял тус тус оногдуулсан ба үүнээс 15 хэрэг буюу 19.4 хувь нь хорих ялыг биечлэн эдэлжээ. Харин 8 хэрэг буюу 10.3 хувьд хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн байх бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7-д зааснаар хөнгөрүүлж хорих ял оногдуулсан 2 хэрэг байгаа нь нийт шийдвэрлэсэн хэргийн 1.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5. 2017-2019 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлөлт, хувиар

Он	Хохирлын хэмжээ (сая.төг)	Нөхөн төлөлтийн хэмжээ (сая.төг)	Нөхөн төлөгдсөн хохирол (хувиар)
2017	54.3	25.6	47.1%
2018	109.0	67.3	62%
2019	374.2	111.8	29.8%

Тус сумын онцлог нь уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүмүүс, аж ахуйн нэгж олонтой, түр оршин суугчид ихтэй ажээ. Сумын хэмжээнд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 38.9 хувийг эзэлж байгаа бол өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг дараагийн байрт эрэмбэлэгдэж байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөлтийн хувь, хэмжээ өмнөх онуудтай харьцуулахад хамгийн бага байгаа шалтгаан нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол өндөр, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нотлох баримтгүй гэсэн үндэслэлээр хэлэлцэхгүй орхидог, нэхэмжлэгч хохирлоо нэхэмжлэхгүй байгаатай холбоотой байна.¹⁰

1.2. Эрүүгийн хуулийн үр нөлөө суманд

Шинэ Эрүүгийн хуулийн онцлог нь ялын хатуу хайрцаглагдсан бодлогоос татгалзаж, тодорхой төрлийн гэмт хэргүүдэд шүүхээс оногдуулж болох ялын төрлийг олон сонголттой болгосон, хорих ялыг биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд анхаарч зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, хорих ялын доод, дээд хэмжээний интервалыг сунгаж өгснөөр шүүх гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэм буруутай этгээдийн хувийн байдалд тохирсон ялыг сонгож оногдуулах боломж нэмэгдсэн гэж үздэг. Хорих ялын хэрэглээг

¹⁰ Судалгааны багийн зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс

бууруулах зорилгын хүрээнд тэнсэх, албадлагын арга хэмжээг шүүхээс ногдуулах нь гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр нь ухамсарлуулах, хохирол нөхөн төлүүлэх, цаашид гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэсэн шинэлэг арга хэмжээ юм.¹¹ Судалгаанд хамруулсан сумдын шүүхээр ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулж буй ялын нөхцөл байдалд шинэ, хуучин хоёр хуулийн хүрээнд харьцуулалт хийж үзлээ.¹²

Хүснэгт 6. Хорих ял оногдуулсан шийдвэрийн дүн

Сумдын нэр	2016 он			2017-2019					
	Шүүхийн шийдвэрийн тоо	Үүнээс		Шүүхийн шийдвэрийн тоо	Үүнээс:				
		Хорих ял	Хувь		Хорих ял			Харьцуулсан хувь	
Нийт	2017	2018	2019						
Бор-Өндөр	10	9	90%	143	32	8	10	14	22.3%
Сайнцагаан	25	20	80%	190	22	4	8	10	11.5%
Улаангом	75	65	86.6%	261	59	16	20	23	22.6%
Ханбогд	30	20	66.6%	77	15	6	4	5	6.4%
Нийт	140	114	81.4%	671	128	34	42	52	19%

Дээрх тоон мэдээллээс харахад сумдын түвшинд хорих ял оногдуулалт нийт дүнгээрээ 62 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь Эрүүгийн хууль хорих ялыг бууруулах чиглэлээр дэвшүүлсэн зорилгодоо хүрч байгааг харуулж байна. Харин Эрүүгийн хуулийн онцлог заалт болох Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх”, Эрүүгийн хуулийн 7.2 “үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга

¹¹ Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, УБ., 2017 он, 72 дахь тал.

¹² Эх сурвалж: www.shuukh.mn сумдын 2016 оны статистик, шийтгэх тогтоолын өнгөн хувь

хэмжээ”, Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 “Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх албадлагын арга хэмжээ” зохицуулалтын хэрэглээг судалж үзэхэд Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйл, 6.7 дугаар зүйлд заасан тэнсэх журмыг шүүх давхар хэрэглэх, эсхүл аль нэгийг нь хэрэглэхгүй байх зэргээр шүүх бүр янз бүрээр хэрэглэсэн байх бөгөөд шүүхээр шийдвэрлэсэн нийт хэргийн 15.9 хувьд 7.1 дүгээр зүйлийг, 4.8 хувьд 6.7 дугаар зүйлийг хэрэглэжээ. Эрүүгийн хуульд заасан ялын зорилгыг хангахаар Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлд заасан үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэхээр хуульчилсан бөгөөд судалгаанд хамрагдсан сумдын түвшинд маш бага тохиолдолд хэрэглэсэн байгаа нь гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн ялын үр нөлөөтэй байх нөхцөл байдалд нөлөөлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт гэмт хэрэгтэн сайн дураар гэм буруугаа хүлээн зөвшөөрч учруулсан хохирлоо нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлсэн тохиолдолд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, гэм буруутай этгээдэд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, тэнсэх зохицуулалтыг шинээр хуульчилсан. Уг заалтын хэрэгжилт, хууль хэрэглээний байдалд шүүхийн шийтгэх тогтоолын түүвэрлэлт болон фокус бүлгийн ярилцлагын үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Энэ тохиолдолд ихэвчлэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан хэргүүд энэ журмаар шийдвэрлэгдэж байх бөгөөд удаа дараа болон байнга энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдэд оногдуулах ялын бодлого алдагдсан байна. Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.3 дугаар зүйлд зааснаар прокурор яллагдагчид оногдуулах ялын төрөл, хэмжээ, эсхүл ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай саналаа шүүхэд гаргаж, шүүх уг прокурорын саналын хүрээнд шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан.

Прокурор санал гаргахдаа удаа дараа гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ялын тэнцвэртэй байх, өмнө нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзалгүйгээр хамгийн доод хэмжээгээр торгох ялыг санал

болгодог, өөрөөр хэлбэл урд нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэгт торгох ял шийтгүүлсэн этгээдэд дахин ял санал болгохдоо дахиад л 450,000 төгрөгийн торгуулийн ял санал болгодог байна. Шүүх шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх гэдэг заалтын хүрээнд прокурорын санал болгосон ялыг оногдуулж байгаа нь судалгааны явцад ажиглагдсаныг дурдах нь зүйтэй. 2015 оны Эрүүгийн хуулийг 2002 оны Эрүүгийн хуультай харьцуулахад ялын төрөл нэмэгдсэн ч шүүхээс нийтэд тусгай ажил хийлгэх ялыг цөөн тохиолдолд хэрэглэжээ. Энэ нь хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаатай холбоотой.

Шүүхээс торгох ялыг хэрэглэхдээ хуульд заасан нөхцөл шалгуурыг төдийлөн анхааралгүй хэрэглэж байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4-т зааснаар шүүгдэгчийн санхүүгийн чадавх, эд хөрөнгийн байдал зэргийг харгалзаж торгуулийг хэсэгчлэн төлүүлж болох талаар заасан ч зарим тохиолдолд байнгын хөдөлмөр эрхэлдэг, санхүүгийн боломжтой шүүгдэгч нарт торгуулийн ялыг хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэжээ. Мөн шүүх шүүгдэгчид торгох ял оногдуулаад Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2.1-д зааснаар ялтанд хохирол төлөх хугацааг үүрэг болгож шийдвэрлэсэн байхад ялтан торгуулийн ялаа төлчхөөд, шүүхээс үүрэг болгосон гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхийг үүрэг болгосон албадлагын арга хэмжээг зөрчих явдал түгээмэл байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 4-т зааснаар шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулахаар заасан ч ялтан шүүхээс оногдуулсан торгуулийн ялаа эдэлсэн байхад дахин шүүхээс түүнд ял оногдуулах нь Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг зөрчих юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан хулгайлах гэмт хэргийн ердийн бүрэлдэхүүний хамгийн хүнд шийтгэл нь 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ялтай, хүндрүүлэх бүрэлдэхүүн нь хоёроос 8 жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан. Тэгвэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар зүйлийн 22.1 дүгээр зүйлд заасан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн ердийн бүрэлдэхүүний хамгийн хүнд санкц нь 1 жилээс 5 жил хүртэлх хугацаагаар хорих ялтай, хүндрүүлэх бүрэлдэхүүн буюу энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол түүнд оногдуулах

хамгийн хүнд санкц нь ердийн бүрэлдэхүүнтэйгээ адил 1 жилээс 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулахаар хуульчилсан байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлд заасан Шударга ёсны зарчимд заасан “...эрүүгийн хариуцлага нь тухайн хүн хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна, мөн гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс угсаа, ...нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролын байдлаар ялгаварлан гадуурхахгүй” гэх зарчмыг илтгэд алдагдуулж ял шийтгэлийг нийгмийн гарал байдал, албан тушаалаар ялгавартай оногдуулахаар хуульчилсан байна.

2002 оны Эрүүгийн хуульд зарим төрлийн гэмт хэргийг шинэ хуулиар гэмт хэрэгт тооцохгүй байхаар хуульчилсан. Энэ нь сумын түвшинд эрүүгийн хуулийг хэрэгжүүлэхэд зарим хүндрэлийг бий болгож байна. Тухайлбал, 2002 оны Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч прокурорын хяналт, шүүхээс оргосон, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцдог байсан бол уг 2015 оны Эрүүгийн хуулиар шүүхээс авсан таслан сэргийлэх арга хэмжээ зөрчиж оргосон үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй болсон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэлээд хүндрэл учруулж байна. Учир нь сум дундын шүүхээр шийдвэрлэгдэж байгаа эрүүгийн хэргийн холбогдогч нь ихэвчлэн малчид, мөн тодорхой оршин суух хаяггүй этгээдүүд байдаг бөгөөд эдгээр хүмүүс нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх явцад оргон зайлах нь маш түгээмэл. Энэ нөхцөл байдлаас шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, хохирогчийн эрх ашиг улам зөрчигдөж, үүний зэрэгцээ яллагдагч, шүүгдэгч оргон зайлсан тохиолдолд хэргийг хэрхэн шийдвэрлэх нь хуулиар тодорхойгүй байна.

Эрүүгийн хуулиар зорчих эрхийг хязгаарлах ялыг шинээр тусгасан. Уг ялыг эрүүгийн хуулийг хэрэглэснээс хойш түдгэлзүүлсэн байсан бөгөөд 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэглэж байна. Ялын зорилго нь хорих ялын тоог бууруулах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт этгээдийг нийгэмшүүлэх зэрэг ач холбогдолтой. Уг ял нь хорих ялын дараа орох хүнд ялын хэлбэр юм. Зорчих эрхийг хязгаарлах ялыг Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн

4-т зааснаар хуульд зааснаас хөнгөрүүлж оногдуулахаар заасан атлаа хөнгөрүүлэн эдлүүлэх журмыг хуульд тусгайлан заагаагүй. Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлөх талаар хуульд тусгасан. Энэ нь хууль хэрэглээний хувьд хоёр өөр төрлийн ялыг журамд нийцүүлэн хэрхэн зөв хэрэглэх нь тодорхой бус, эргэлзээтэй байдлыг үүсгэж байна.

ХОЁР. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨ СУМЫН ТҮВШИНД

2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төрөл, удирдлага зохион байгуулалт

2015 оны эрүүгийн хуулийн шинэчлэлийн нэг чухал зорилт бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах, гэмт хэргийн гаралтыг ихэсгэхгүй байх буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэсэн. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад цогц арга хэмжээ¹³ байхаар хууль тогтоомжоор зохицуулсан.

Судалгааны хамрах хугацаанд 1997 оны Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх тухай хууль үйлчилж байсан бөгөөд тус хуулийн шинэчилсэн найруулга болох Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдөр батлагдаж, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхлээд байна. Тиймээс сонгосон сумдын түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, түүний үр дүнд өмнөх хуулийн зохицуулалтад хамаарах үзүүлэлтээр төлөвлөлт-тайлагнал-хяналт шинжилгээ гэсэн үе шатаар дүн шинжилгээ хийлээ.

Гэмт хэргийн гол шалтгаан нь улс орны нийгэм, эдийн засгийн орчин, ядуурал, ажилгүйдэл, архидалт, хувь хүний боловсрол, мэдлэг зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг ч иргэдэд гэмт хэргийн хор уршгийг таниулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг шат дараатай, оновчтой зохион байгуулах нь чухал ач холбогдолтой байдаг.¹⁴

¹³ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2019 оны 6 дугаар сарын 6

¹⁴ Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлахад зориулсан гарын авлага УБ., 2018 он 1-р тал

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төрлийг дараах байдлаар томъёолсон. Үүнд:

- *Ерөнхий арга хэмжээ* – гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээ;
- *Тусгай арга хэмжээ* – тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээ;
- *Нэг бүрчилсэн арга хэмжээ* – тодорхой этгээд гэмт хэрэг үйлдэхээс, давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд ХЗДХС-аар ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл (ГХУСАЗЗ гэх) удирдан зохион байгуулах бөгөөд аймаг, нийслэлийн ИТХ-ын даргаар ахлуулсан салбар зөвлөл (ГХУСАЗСЗ гэх), Гэр бүлийн хүчирхийлэл, Хүн худалдаалах, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг, Мал хулгайлах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэсэн 6 дэд зөвлөлтэй бөгөөд үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал, удирдлага зохион байгуулалтын хувьд босоо тогтолцоогоор үйл ажиллагаа явуулж байна.¹⁵

2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал, үр нөлөө

ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь тухайн аймаг, суманд гарч байгаа гэмт хэргийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд гэмт хэрэг гарч буй шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйл, төрөл, хэлбэр, түүнд хамаарал бүхий статистик тоо баримтыг шинжлэн судлах, түүнд тулгуурласан үйл ажиллагааны төлөвлөлт хийх, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах явдал юм.

¹⁵ www.cccp.mn

Судалгааны ач холбогдол, хамрах хүрээний хувьд эрэмбэлж үзсэний үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төрлүүдээс тусгай арга хэмжээг удирдлага зохион байгуулалтын босоо тогтолцооны хүрээнд аймаг, сумын түвшинд хэрхэн төлөвлөж, хэрэгжүүлж, тайлагнаж байгаа болон түүнд тавих хяналт, төлөвлөлтийн ажлын үр нөлөөнд¹⁶ гол анхаарлаа хандууллаа. Үүний тулд сумын түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэр зэрэг бодитой төлөвлөдөг болох, сумын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эсэхийг тодруулахыг зорилоо.

2.2.1 Төлөвлөлтийн үр нөлөө

Аймаг, сумын түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг жил бүр тогтмол төлөвлөж, хэрэгжүүлж ирсэн сайн үзүүлэлт байгаа ч ГХУСАЗЗ-ийн ажиллах журам¹⁷-д улсын болон аймаг, сумын түвшинд төлөвлөлт, тайлагналд тавигдах шаардлага тусгагдаагүйн улмаас судалгаанд хамруулсан аймаг, сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайлангийн загвар өөр өөр байна.

¹⁶ Үр нөлөөтэй байх зарчим “Дэвшүүлсэн зорилгыг биелүүлж, төлөвлөсөн үр дүнд хүрэхтэй холбоотой шалгуур бөгөөд... хөтөлбөр, үйл ажиллагаа өмнөө тавьсан зорилтуудаа биелүүлсэн эсэхийг тодорхойлно. Үр нөлөөний тухай авч үзэхдээ шууд үр дүн буюу гарц, эцсийн үр дүн буюу өгөөж хоёрыг ялгаж үзнэ. Хөтөлбөрийн зорилгын биелэлтэд ололт амжилт ажиглагдаж байвал үр нөлөө гарч байна гэж үзнэ”. Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 300

¹⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт

Хүснэгт 7. Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний загвар

Загвар 1. Бор-Өндөр сумын ГХУСАЗСЗ-ийн 2018 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө

Үйл ажиллагааны төрөл	Хэрэг-жүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн	Хугацаа	Биелэлт
-----------------------	--------------------------	---------------	---------	---------

Загвар 2. Бор-Өндөр сумын ГХУСАЗСЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага ГХУСАЗСЗ-ийн гишүүн	Хамтран ажиллах байгууллага
-------------------------------	-----------------------------------	---------	--	-----------------------------

Загвар 3. Хэнтий аймагт ГХУСАЗСЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Хугацаа	Төсөв	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
-------------------------------	---	---------	-------	----------------------	-----------------------------

Загвар 4. Дундговь аймгийн Сайнцагаан сумын ГХУСАЗСЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх, байгууллага албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт
---------------------------	---------	---------------------------------------	--	------------------

Загвар 5. Увс аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2017 онд хийх ажлын төлөвлөгөө

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хяналт тавих албан тушаалтан	Хүрэх үр дүн
---------------------------	---------	----------------------	------------------------------	--------------

Дээрх хүснэгтээс харахад үйл ажиллагааны төлөвлөлтийн үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг багтааж, төлөвлөлтийг иж бүрэн, тодорхой, хэмжигдэхүйц, ач холбогдолтой байдлаар төлөвлөдөггүй болох нь харагдаж байна. Тухайлбал загвар 1, загвар 2 буюу Бор-Өндөр сумын 2018, 2019 оны төлөвлөлтийг харьцуулбал, 2018 оны төлөвлөлтөд “хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт” болон “хамтран ажиллах байгууллага” байхгүй байгаа бол хоёр оны төлөвлөлтөд нийтлэг байдлаар “төсөв” төлөвлөөгүй байна. Төлөвлөлтөд санхүүгийн эх үүсвэрийг төсөвлөхгүй орхих нь төлөвлөгөө биелэх боломжийг хязгаарлах нь тодорхой.

Сонгосон аймаг, сумдын тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ГХУСАЗСЗ-ийн төлөвлөлт нь төлөвлөлтийн нийтлэг шалгуур үзүүлэлт буюу зорилт нь үр дүнд суурилсан байх, бодит биелэгдэхүйц байх, арга хэмжээг хэрэгжүүлэхүйц нөөц, төсөв, санхүүгийн эх үүсвэр тодорхой байх, асуудлын мөн чанар, суурь түвшинд тулгуурлаж, хүрэх түвшнийг тооцсон байх зэрэг нийтлэг шалгуурыг хангаагүй байна. Тэрчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээгээр төлөвлөгдөөгүй, өмнөх бүлэгт дурдсан аймаг, сумын гэмт хэргийн гаралтын давтамж, тоон мэдээлэл, нөхцөл байдалтай уялдаагүй, түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлийг баримтлаагүй зэрэг нийтлэг дүр зураг харагдаж байна. Үүнийг тодруулахын тулд Хэнтий аймаг, Бор-Өндөр сумын ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөнд шинжилгээ хийж, туссан үйл ажиллагааг задлан харууллаа. Үүнд:

- Хэнтий аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2018 оны төлөвлөгөө¹⁸ нь дээрх нийтлэг шалгууруудыг хангаагүй байхаас гадна ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээ буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төрлөөр хийгдээгүй, Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 16, Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл чиглэлээр 1, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 3, Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд

¹⁸ Хэнтий аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүтээр тогтоолын хавсралт

4, Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 4, Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 1, Хууль сурталчлах ажлын хүрээнд 2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 нийт 37 арга хэмжээг төлөвлөжээ.

- Бор-Өндөр сумын ГХУСАЗСЗ-ийн 2018 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө мөн л төлөвлөгөө боловсруулах нийтлэг шалгууруудыг хангаагүйн зэрэгцээ төлөвлөгөөний бүтцийн хувьд Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд 5, Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4, Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 нийт 25 ажил төлөвлөжээ.

Дээрх төлөвлөлтийн ерөнхий дүр зургаас харахад өмнөх бүлэгт өгүүлсэн Бор-Өндөр суманд 2017-2018 онд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалтай уялдаагүй нь харагдаж байна.

Төлөвлөсөн үйл ажиллагаатай нэг бүрчлэн танилцахад хэрэгжүүлэхээр тусгасан үйл ажиллагааны өмнөх оны мэдээлэл буюу суурь түвшин өнөөгийн байдлын талаарх мэдээлэл байхгүй, яагаад тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон хэрэгцээ шаардлагаа тодорхойлоогүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлснээр гарах үр дүнг тодорхойлоогүй байдлаар төлөвлөжээ. Түүнчлэн аймаг сумдад нийтлэг анзаарагдаж байгаа бас нэг алдаа дутагдал бол тухайн үйл ажиллагааг хариуцах эзэн, хамтран ажиллах байгууллага, түүнд хяналт тавих субъектийн талаар тусгаагүй, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн талаар мэдээлэл огт байхгүй байна.

Хүснэгт 8. Бор-Өндөр сумын ГХУСАЗСЗ-ийн 2018 онд
хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө (хэсэгчлэн авав)

Үйл ажиллагааны төрөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн	Хугацаа
Удирдлага зохион байгуулалтын ажил	1.1. ГХУСАЗСЗ-ийн гишүүд орон нутгийн телевизтэй хамтран иргэдэд хуулийн мэдлэг олгох зорилгоор телевизийн шууд нэвтрүүлэг хийх	ГХУСАЗ СЗ-ийн нарийн бичгийн дарга	Хагас жилд 1-ээс доошгүй удаа

Дүгнэлт, тайлбар: Хамрах хүрээ буюу иргэдэд гэдэгт зорилтот бүлэг нь хэн болох, мөн ямар хуулийн мэдлэгийг, ямар шат дараатайгаар олгох нь тодорхойгүй. Хэрэгжүүлэх арга хэмжээн дээр ГХУСАЗСЗ-ийн гишүүд гэсэн хэр нь хариуцах эзэн нь ганц тоон дээр буюу нарийн бичгийн дарга, мөн хагас жилд 1-ээс доошгүй удаа гэсэн байна. Логик дарааллаар бодоход зөвлөлийн гишүүд гэж олон тоон дээр бичигдсэн байгаа учраас энэ нэвтрүүлгийг улиралд 2-оос доошгүй удаа төлөвлөх боломжтой нь харагдаж байна. Тухайлбал, 1 удаагийн нэвтрүүлгээр 2 гишүүн оролцох ингэхдээ нэг хуулийн танилцуулгыг хийж болох юм. Хуулийг сурталчлах нөлөөллийн ажлыг тодорхой давтамжтай, үргэлжилсэн байдлаар, иргэдийн насны онцлогт тулгуурлан төлөвлөж, хэрэгжүүлбэл энэ ажлын үр нөлөө сайжирна. Мөн энэ арга хэмжээнд хувийн хэвшлийг татан оролцуулахаар төлөвлөсөн хэр нь түүнд шаардагдах хөрөнгө төсөвлөгдөөгүй байгаа учраас хэрэгжих магадлал буурахаар байна.

Гурав. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр	3.3. Малын хулгайн гэмт хэргийн гаралт буурахгүй байгаагай холбогдуулан иргэдийн ухамсрыг дээшлүүлэх зорилгоор Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, брошюр тараах.	-	Жилд 1-ээс доошгүй удаа.
---	--	---	--------------------------

Дүгнэлт, тайлбар: Мал хулгайлах гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь тоон болон чанарын үзүүлэлтээр баталгаажуулж, иргэдийн ухамсрыг дээшлүүлэх үү, хууль зүйн мэдлэг, мэдээлэл үү гэдэг нь тодорхойгүй, тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон боломжит хувилбараас яагаад зөвхөн зөвлөмж, брошюр тараахыг сонгосон үндэслэл байхгүй, энэ ажлыг хэрэгжүүлэх эзэн байхгүй, жилд 1 удаа зохион байгуулах тул хэрэгжилт, үр нөлөөг тооцох боломжгүй байна.

Дөрөв. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр	4.3. Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, яриа, таниулга зохион байгуулах	ГХУСАЗ СЗ, ЗДТГ Цагдаагийн хэлтэс	Улирал бүр
---	---	-----------------------------------	------------

Дүгнэлт, тайлбар: Энэхүү арга хэмжээний зорилтот бүлэг нь хүүхэд байж болох ч төлөвлөсөн бусад 4 арга хэмжээ нь сумын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийг хэн голчлон үйлдэж байгаа, хохирогчид нь ямар ямар нас, хүйсийн хүмүүс болох, энэ төрлийн гэмт хэрэг гарч байгаа суурь шалтгаан юу болох гэх мэтчилэн асуудлыг цогц, иж бүрэн зураглалаар хараагүй, салангид арга хэмжээг төлөвлөсөн байгаа нь тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд үзүүлэх үр нөлөө бага байхаар байна.

Хүснэгтээр үзүүлсэн нөхцөл байдал сонгосон аймаг, сумын түвшинд ижилхэн дүр зурагтай байна. ГХУС ажлын төлөвлөлтийг тухайн шатанд өөрийн аймаг, сумын гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан нөхцөл, үр дагаврыг арилгах зэргээр цогц нэгдмэл байдлаар төлөвлөх нь илүү ач холбогдолтой болно.

2.2.2 Тайлагнал, хяналтын үр нөлөө

Судалгаанд хамрагдсан аймаг, сумдын ГХУСАЗСЗ-ийн 2017-2019 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох цахим хуудаснаас *doc, pdf* өргөтгөлтэй файл хэлбэрээр эсхүл холбогдох албан тушаалтанд хүсэлт гаргаж, хэвлэмлээр болон цахим шуудангаар авч, хамаарах

оны төлөвлөгөөтэй тулган баталгаажуулж, харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийсэн болно. Төлөвлөлтийн нийтлэг шалгуур үзүүлэлтийг хангаагүй, төлөвлөгөө нь үр нөлөө багатай, зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь харилцан уялдаагүй байлаа.

Кейс 1. Дундговь аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаас

Хийгдсэн ажил: ...Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ (архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар тогтоосон захирамж гаргуулсан)...

Хүрсэн үр дүн: Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, аймгийн “Архигүй Дундговь” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд стандартын шаардлага хангахгүй согтууруулах ундаа худалдаалагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Архи амьдралын дайсан” арга хэмжээг 2017 оны 1 дүгээр сарын 19-ний өдрөөс нэг сарын хугацаатай зохион байгуулсан.

Дээрх тайлагналын жишээнээс харвал, “Архигүй Дундговь” хөтөлбөрийн зорилго нь аймгийн хэмжээнд архинаас үүдэлтэй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэсэн зорилт биш “стандартын шаардлага хангахгүй согтууруулах ундаа худалдагдах”-аас сэргийлэхэд чиглэгдсэн мэтээр уншигдаж байна.

Аймаг, сумын ГХУСАЗСЗ нь тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлээд гарсан үр дүнг тайлагнах биш тухайн байгууллага, албан тушаалтан өөрийн хийсэн захиргааны шинжтэй болон өдөр тутмын ажлаа тоочих, ямар арга хэмжээний зургийг, хэзээ авсан нь тодорхойгүй олон нийтийг хамарсан үйл ажиллагааны фото зургийг их хэмжээгээр байршуулах явдал түгээмэл байна. Мөн тухайн жилд төлөвлөсөн нийт ажлын биелэлтийг тоон болон чанарын үзүүлэлтээр харьцуулдаггүй, биелсэн болон биелээгүй ажлыг ялгаж харуулдаггүй, үйл ажиллагааг биелүүлээгүй шалтгаан нөхцөлийг дурддаггүй зэрэг нийтлэг дутагдал байна.

Аливаа хөтөлбөр, төлөвлөгөө түүний хэрэгжилтэд хяналт, шалгалт чухал ач холбогдолтой. Хяналт шинжилгээний зорилго нь өргөн утгаараа хөтөлбөр, төлөвлөгөө, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршдог.¹⁹ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт, тайлагнал дээр гарч байгаа дээрх нөхцөл байдлын шалтгаан нь төлөвлөлт, тайлагналын үе шатанд сумын түвшинд болон аймгийн ГХУСАЗСЗ-өөс хяналт тавьдаггүйтэй холбоотой байж болох юм. Хэдийгээр нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалттай ч нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хувьд аймгийн ИТХ, сумын иргэдийн ИТХ-д үүрэг чиглэл өгөх, биелэлтийг хангуулах эрх зүйн зохицуулалт бусад хууль тогтоомжоор нээлттэй.

Нөгөө талаас, сумын ГХУСАЗСЗ өөрийн төлөвлөлт, тайлагналын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх, үйл ажиллагааныхаа үр дүнг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллах шаардлагатай. Монгол Улсад ГХУСАЗСЗ, түүний ажлын алба нь аймаг, сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан хэмээн тайлагнасан ч тодорхой үр дүнг илэрхийлэх үзүүлэлт байхгүй байна.

¹⁹ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол. Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам

ДҮГНЭЛТ

- Судалгаанд хамрагдсан сумдын түвшинд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд буюу хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралт хамгийн өндөр байна.
- Сумдын түвшинд хорих ял оногдуулалт нийт дүнгээрээ 62 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь Эрүүгийн хууль хорих ялыг бууруулах чиглэлээр дэвшүүлсэн зорилгодоо хүрч байгааг харуулж байна.
- Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлд заасан үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэхээр хуульчилсан ч сумдын түвшинд маш бага тохиолдолд хэрэглэсэн байгаа нь гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн ялын үр нөлөөтэй байх нөхцөл байдалд нөлөөлж байна.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэгт гэмт хэрэгтэн сайн дураар гэм буруугаа хүлээн зөвшөөрч учруулсан хохирлоо нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлсэн тохиолдолд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, гэм буруутай этгээдэд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, тэнсэх зохицуулалтыг тусгасан бөгөөд сумын түвшинд ихэвчлэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан хэргүүд энэ журмаар шийдвэрлэгдэж байгаа нь удаа дараа болон байнга энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдэд оногдуулах ялын бодлогыг алдагдуулж байна.
- 2002 оны Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч прокурорын хяналт, шүүхээс оргосон, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцдог байсан бол уг 2015 оны Эрүүгийн хуулиар шүүхээс

авсан таслан сэргийлэх арга хэмжээ зөрчиж оргосон үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй болсон нь сумын түвшинд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад хүндрэл учруулж байна.

- Хорих, зорчих эрхийг хязгаарлах хоёр өөр төрлийн ялд ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх журмыг хэрхэн хэрэглэх нь тодорхой бус, эргэлзээтэй байдлыг үүсгэж байна.
- Сумын түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй, төлөвлөлтийг иж бүрэн, тодорхой, хэмжигдэхүйц, ач холбогдолтой байдлаар төлөвлөдөггүй нь хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөг бууруулж, гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй болгож байна.
- Сумын түвшинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг нэгдмэл байдлаар, бодитой судалж тогтоогоогүй, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг тодорхойлох ажил хангалтгүй байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх боломжгүй болгож, нийтлэг байдлаар сургалт, сурталчилгаа, худалдан авалт (тоног төхөөрөмж, автомашин гэх мэт), эргүүл жижүүр, олон нийтийн цагдаагийн хяналтаар нийтийн хэв журмыг сахиулах зэргээр төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь үр нөлөөг бууруулж байна.
- Сумын түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт, тайлагналыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу зохион байгуулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга барилыг шинэчлэх шаардлага тулгамдаж байна.

ЗӨВЛӨМЖ

- Эрүүгийн хуулийн онцлог зохицуулалтууд болох 7.1-д “хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалтаас гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн” гэдэг зохицуулалтыг шүүх хэрэглэхдээ хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол бүрэн хангагдахуйц байдлаар буюу хэзээ, хэрхэн, яаж нөхөн төлөх тухай шийтгэх тогтоолд нэг бүрчлэн тусгах;
- Шүүхээс оногдуулж буй торгох ял нь шүүгдэгчийн хувийн байдал, эд хөрөнгө, бодит орлогын хэмжээнд тулгуурлаагүй нөхцөлд ялын зайлшгүй хэрэгжих зарчим алдагдаж, гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийг нэмж хохироохгүй байх гэсэн Эрүүгийн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөж байгааг шүүх анхаарах;
- Эрүүгийн хуулийн 7.1 дэх заалт болох хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалтын хэрэгжилт болон хэргийн оролцогчийн эрх зүйн байдалд нөлөөлөх үр дагавар, хууль хэрэглээний талаарх асуудлыг нэг мөр болгох;
- Эрүүгийн хууль тогтоомжийг сумын түвшинд хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг шийдэхэд анхаарах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга барил, хандлагыг шинэчлэх, “*Community or locally-based crime prevention*” буюу орон нутгийн түвшинд олон нийтийн оролцоог хангасан байдлаар төлөвлөж хэрэгжүүлдэг болох;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зам тээврийн осол, хулгай, хүчин гэх мэтээр төрөлжүүлэх, төлөвлөлтийг судалгаа шинжилгээ, асуудлын мөн чанар, суурь түвшинд тулгуурлаж, хүрэх үр дүнг тооцсон, бодитой биелэгдэхүйц байхаар иж бүрэн төлөвлөх, хэрэгжилтийг тоон болон чанар үзүүлэлтээр харьцуулж, үр дүнг тооцдог байх;
- Судалгаанд хамрагдсан сумдын гэмт хэргийн тоон үзүүлэлтэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг хамгийн өндөр хувийг эзэлж байгаа тул гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг бууруулах ажлыг эрчимжүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Монгол Улсын хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Эрүүгийн хууль, 2002, 2015
3. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 2002
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017
5. Шүүхийн тухай хууль, 2015
6. Цагдаагийн албаны тухай хууль, 2017
7. Прокурорын тухай хууль, 2017
8. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015
9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, 1999
10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019
11. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал батлах тухай Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

Судалгаа, нэг сэдэвт бүтээл

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн “Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ”, УБ., 2018
2. Улсын дээд шүүх, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын тайлбар, УБ., 2015
3. Эрүүгийн хуучин ба шинэ хуулийн зөрлөгт үүссэн ээдрээ, эмгэг, эсрэгцэл. Хуульч Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган нэг сэдэвт өгүүллэг
4. Гэмт хэргийн цагаан ном, УБ., 2017-2018
5. Монгол Улсын шүүхийн тайлан, 2016-2019
6. Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2016-2019
7. Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлахад зориулсан гарын авлага, УБ., 2018
8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй, МУ-д ГХУСА33, Монголын Криминологичдын холбоо, УБ., 2017

9. “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, Үндэсний аудитын газар, УБ., 2018.

Холбогдох байгууллагын тайлан, төлөвлөгөө

1. Дундговь аймгийн ГХУСАЗЗ-ийн 2017-2019 оны төлөвлөгөө, тайлан (Сайнцагаан сум)
2. Өмнөговь аймгийн ГХУСАЗЗ-ийн 2017-2019 оны төлөвлөгөө, тайлан
3. Хэнтий аймгийн ГХУСАЗЗ-ийн 2017-2019 оны төлөвлөгөө, тайлан
4. Увс аймгийн ГХУСАЗЗ-ийн 2017-2019 оны төлөвлөгөө, тайлан
5. Хэнтий аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2018 оны 01 дүгээр тогтоол, тогтоолын хавсралтаар баталсан “Аймагт ГХУСАЗСЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”
6. ХЗДХЯ, ГХУСАЗЗ-ийн 2017-2019 оны төлөвлөгөө, тайлан.

Цахим эх сурвалж

www.legalinfo.mn	www.legalinstitute.mn
www.supremecourt.mn	www.prokuror.mn
www.police.gov.mn	www.mojha.gov.mn
www.shuukh.mn	www.forum.mn
www.cccp.mn	www.uvs.nso.mn
www.khentii.nso.mn	www.dundgovi.nso.mn
www.umnugovi.nso.mn	www.uvs.khural.mn
www.khentii.khural.mn	www.dundgovi.khural.mn
www.umnugovi.khural.mn	

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ, ЯЛ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛЖ БУЙ БАЙДАЛ ОРОН НУТАГТ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Багийн ахлагч:

Ж.САРУУЛ

“Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ-ын гүйцэтгэх захирал,
Хэл бичгийн ухааны магистр

Судлаачид:

Л.ОЮУНЦЭЦЭГ

Хууль зүйн туслалцааны төвийн Ховд аймаг дахь
салбарын Улсын өмгөөлөгч

Ж.ЦЭЦЭГМАА

“Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ-ын судалгаа,
шинжилгээний асуудал хариуцсан ажилтан

2021 он, Ховд хот

ГАРЧИГ

УДИРТГАЛ	45
СУДАЛГААНЫ ДҮН	48
1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин, орон нутгийн бодлого хөтөлбөр түүний хэрэгжилт	48
2. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, бусад асуудал	52
2.1. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, статистик үзүүлэлт	52
2.2. Холбогдох төрийн байгууллага буюу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаа	55
2.3. Гэр бүлийн хүчирхийлэлд үзүүлэх хэвлэл мэдээлэл олон нийт, нийгмийн сүлжээний нөлөө	57
3. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлт	60
ДҮГНЭЛТ	65
САНАЛ ЗӨВЛӨМЖ	69
НОМ ЗҮЙ	70
ХАВСРАЛТ.	
Гэр бүлийн хүчирхийллийн талаар иргэдээс авсан санал асуулгын дүн	71

УДИРТГАЛ

“Жавхлант гэрэлт ирээдүй” ТББ нь нь Нээлттэй Нийгмийн Форумын дэмжлэгтэйгээр нийтийн эрх ашгийн өмгөөлөл, нөлөөллийн, бодлогын судалгааны чиглэлээр гурав дахь төслөө амжилттай хэрэгжүүлж байна. Тус ТББ нь иргэдийн мэдэх эрхийг дэмжих, хүний эрх, хууль эрх зүйн мэдлэг мэдээллээр хангах, хувь хүн, хуулийн этгээдийн эрх зүйн болон эрүүл мэнд, боловсролын асуудлаарх мэдлэг, хандлагыг сайжруулахад зөвлөн туслах, сургалт нөлөөллийн ажил явуулах зорилготойгоор 2019 оны 3 дугаар сард байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Гэр бүл бол нийгмийн анхдагч нэгж бөгөөд гэр бүлийн бүрэн бүтэн байдал нь нийгмийн гол үнэт зүйл юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан байдаг. Хүн гэр бүлдээ аюулгүй, амар тайван байх нь хамгийн чухал хэрэгцээний нэг билээ. Үүнийг алдагдуулж буй гол хүчин зүйл бол гэр бүлийн хүчирхийлэл юм.

Жилээс жилд гэр бүлийн хүчирхийллийн тоон үзүүлэлт өссөөр байгааг статистик мэдээлэл харуулдаг. Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар хийсэн цөөнгүй судалгаа байх бөгөөд сүүлийн жилүүдэд хийгдсэн томоохон судалгааны нэг нь “Монголын эмэгтэйчүүдийн амьдралын туршлага” хэмээх судалгаа юм. Уг судалгаа 2017 онд гарсан байна. Харин орон нутгийн түвшинд, тэр дундаа Ховд аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж буй ял шийтгэл, үр нөлөөний талаар хийсэн судалгаа байхгүй байна.

Тиймээс гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гарсан зөрчил, гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл үр нөлөөтэй эсэхийг энэхүү судалгаагаар авч үзэхийг зорилоо. Мөн түүнчлэн орон нутгийн түвшинд гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг судалж буйгаараа

уг судалгаа нь онцлогтой юм. Гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж буй ял, шийтгэлийн үр нөлөөг орон нутгийн түвшинд судлан гаргаж ирснээр анхан шатны нэгжид хуулийн хэрэгжилт хэр байгаа болон авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний үр өгөөжийг үнэлж дүгнэх боломж бүрдэнэ. Мөн хууль тогтоомжид буй хийдэл, хууль хэрэглээний алдааг олж илрүүлэх ач холбогдолтой.

Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй нөхцөл байдлыг орон нутгийн түвшинд судалж, үр дүнг тодорхойлох зорилго тавьж дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин, орон нутгийн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг судлах;
- Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагаа, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний үзүүлж буй нөлөөг тодорхойлох;
- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн үр дүнг судалж санал, зөвлөмж гаргах.

Судалгааны арга зүй

Судалгааны хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчил үйлдэж Ховд аймгийн цагдаагийн газарт бүртгэгдсэн нийт 68 хэрэгт дүн шинжилгээ хийж, баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн хүмүүстэй фокус бүлгийн уулзалт, хэлэлцүүлэг хийж, үр дүнг тандлаа. Мөн Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ гэх)-т бүртгэгдсэн кэйс болон холбогдох бусад бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж холбогдох бусад төрийн ажилтан, албан хаагчдаас асуулга авав. Түүнчлэн үндэсний хэмжээнд цацагдаж байгаа телевизийн томоохон таван суваг, орон нутгийн дөрвөн телевизийн контентод ажиглалт, дүгнэлт хийлээ.

Мөн анкет асуулгын аргаар аймгийн төвийн Цаст Алтай цогцолбор сургууль, гэр хорооллын хэсэгт байх 7-р сургууль болон тус сургуулийн дотуур байрны нийт 100 хүүхдээс судалгаа авлаа. Насанд хүрэгчдийн судалгаанд 100 эмэгтэй, 50 эрэгтэй, мөн гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэж баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн 50 эрэгтэйг хамрууллаа.

СУДАЛГААНЫ ДҮН

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин, орон нутгийн бодлого хөтөлбөр түүний хэрэгжилт

Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Зөрчлийн тухай, Хүүхэд хамгааллын тухай болон Эрүүгийн хуулиуд, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна. Харин Ховд аймаг нь “Гэр бүлийн хөгжил хамгааллыг дэмжих дэд хөтөлбөр”, “Жендерийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”, “Тайван амгалан Ховдчууд хөтөлбөр”, “Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүд баталж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж байна.

Гэр бүлийн хөгжил хамгааллыг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг¹ 2017 онд баталсан бөгөөд уг төлөвлөгөө 2017-2020 оны хооронд хэрэгжихээр төлөвлөгджээ. Уг хөтөлбөр хэрэгжиж эхлэх үетэй харьцуулахад гэр бүлийн хүчирхийлэл жилээс жилд өссөн буюу нэмэгдсэн байгаа нь гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилтдоо тус хөтөлбөр хүрч чадаагүй хэмээн дүгнэж болохоор байна. Тухайлбал, 2014-2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нийт 144 гомдол бүртгэгдэж байсан бол зөвхөн 2020 оны эхний 8 сарын байдлаар 118 гомдол бүртгэгджээ. Мөн түүнчлэн гэр бүл салалт 2014-2016 онд жилд дунджаар 35-40 байсан бол 2017-2019 онд жилд дунджаар 40-44 болж өсжээ.

“Тайван-Амгалан-Ховдчууд” хөтөлбөр Ховд аймгийн ИТХ-ын 2017 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан билээ. Энэ хөтөлбөр нь гэр бүлийн хүчирхийллээс² урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг хэтэрхий нүсэр, өргөн цар хүрээтэй төлөвлөсөн нь бодитой бус болсон

¹ Гэр бүлийн хөгжил хамгааллыг дэмжих аймгийн дэд хөтөлбөр, 2017 он

² Гэр бүлийн хөгжил хамгааллыг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн тайлан, 2017-2019 он

гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал, тус хөтөлбөр гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах үр дүнд хүрэхээр тодорхойлсон. Үүнд:

- Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд мэргэжлийн түвшинд шуурхай хамгаалагдах баталгаа бүрдүүлэх;
- Хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг таслан зогсоох мэргэжлийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлдэг болох;
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн ажлын цогц үйлчилгээг үзүүлэх төр ба иргэний нийгмийн байгууллагын салбар хоорондын сүлжээт тогтолцоо бий болж, хамтран ажиллах чадавх, бүтэц, зохион байгуулалтын механизм бэхжиж, боловсронгуй, тодорхой, хүртээмжтэй болгох;
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийллээс ангижрах урт, богино хугацааны нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ авах таатай орчин бүрдүүлэх;
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд тусгайлсан цогц үйлчилгээг хүргэж, хүчирхийллээс хамгаалах нөхцөл боломж бүрдүүлэх;
- Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх замаар гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл бүхий бүлгийг тусгайлан хүчирхийллээс хамгаалах нөхцөл бүрдүүлэх;
- Хамт олон, хөрш зэрэг нийгмийн бичил хэсэг нь хүчирхийлэлд өртөгсдөд мэдрэмжтэй, хариуцлагатай хандах ухамсар төлөвшинө;
- Гэр бүлд хүний эрхийг хүндэтгэн үзэх хандлага төлөвшин гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлнэ.

Хөтөлбөр хэрэгжээд 3 жилийн хугацаа өнгөрсөн ч Ховд аймагт гэр бүлийн хүчирхийлэл буурсангүй, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах байр баригдсан ч стандарт шаардлага хангаагүйн улмаас ашиглалтад оролгүй нэлээд удсаны эцэст 2020 оны жилийн эцсээр ашиглалтад орж үйл ажиллагаа нь эхэлсэн. Хэдийгээр чухал зорилт туссан ч хэрэгжүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил төлөвлөж, зохион байгуулаагүйн улмаас тунхгийн шинжтэй хөтөлбөр болсон гэж үзэж болох юм.

Харин тус хөтөлбөрийн зарим зорилт тодорхой хэмжээнд хэрэгжсэн нь гэр бүлийн хүчирхийлэл гэж юу болох, хэрхэн, хаана хандах ёстой болохоо иргэд мэддэг болж, улмаар гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байгаа болохыг аймгийн шүүгчид онцолсон.

Дараагийн нэг хөтөлбөр бол “Залуучуудын хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөр⁴ бөгөөд залуучуудын оролцоо, түншлэл, эрүүл мэнд, боловсрол, хөгжлийг дэмжих, тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн залуучуудын сонирхол давуу талд нь тулгуурлан нийгмийн олон талт дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлт, ажил орлоготой, хэвийн амьдрах боломж нөхцөлийг бүрдүүлэх гэсэн үндсэн таван зорилт дэвшүүлсэн байна. Ялангуяа ажилгүйдлийн улмаас гэр бүлийн зөрчил ихээхэн гарч байгаа үед залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь чухал ач холбогдолтой гэж хэлж болно. Харин залуучуудын дунд түгээмэл байдаг үл ойлголцол, гэр бүлийн маргаан, стрессийг хэрхэн даван туулах гэх мэт асуудлыг тусгаагүй байдлаас дүгнэвэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилт байхгүй байна гэж үзэж болохоор байна.

“Жендерийн тэгш байдлыг хангах” аймгийн дэд хөтөлбөрийн⁵ хувьд олон нийтийн дундах хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх зорилгоор боловсруулагджээ. Тус хөтөлбөрт гэр бүлийн хөгжлийг дэмжин, хүн амын бүлгүүдийн хөгжил, хамгааллыг сайжруулан, жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулах үр нөлөөтэй арга хэмжээ авах, хүн амын зорилтот бүлгийн хөгжил хамгааллыг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлыг жендерийн мэдрэмжтэй болгох гэсэн зорилт туссан нь сайшаалтай. Мөн тус хөтөлбөрийн онцлох зүйл бол зорилт тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгаж өгсөн явдал байв. Гэвч цаашид үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад анхаарах шаардлагатай.

Ховд аймагт хэрэгжиж буй дээрх хөтөлбөрүүдийг шинжлэхэд хийх ажлаа аль болох бодитой, тодорхой, хүрч болохуйц, хэрэгжих боломжтой, хэмжигдэхүйц байдлаар төлөвлөөгүйгээс үүдэн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзлээ. Мөн төрийн албан хаагчдын ажлын ачаалал, ажил үүргийн хуваарийг нягталж үзэх нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд хамгийн их үүрэгтэй байхаар тусгагдсан нийгмийн ажилтнуудын ажлын ачаалал их, энэ

чиглэлээр хангалттай бэлтгэгдээгүй байгааг анхаарах нь зүйтэй. Түүнчлэн нэгэнт зөрчил үйлдсэн этгээдтэй ажиллаж байгаа цагдаагийн ажилтнуудын ажил үүргийг тодорхой болгож, мэргэшсэн байдлыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай юм.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудын ихэнх нь төрийн албан хаагч, эцэг эхийн зөвлөл гэх мэт нийгмийн идэвхтэй хэсэгт чиглэсэн байгаагаас үзэхэд зорилтот бүлэгтээ хүрч чадаагүй гэж дүгнэж болохоор байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүмүүсийн статистик мэдээллээс харахад ихэнх нь бүрэн дунд боловсролтой, ажилгүй иргэд байдаг. Мөн төрөөс хэрэгжүүлж буй аливаа ажил, үйлчилгээ уламжлалт арга барилаар буюу танхимын сургалт, хурал, семинар, олон нийтийг хамарсан баяр ёслолд илүүтэй чиглэжээ. Энэ нь орчин цагийн хүмүүсийн эрэлт хэрэгцээ, амьдралын хэмнэлд төдийлөн хүртээмжтэй байж чадахгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд Зөвлөл байгуулагдаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой нийт 33 журмыг холбогдох яамдаас батлан гаргажээ. Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах чиглэлээр хууль сахиулагч, хамтарсан багийн мэргэжилтнүүдийг сургасан гээд үр дүнтэй алхмууд хийгдсэн нь сайшаалтай. Гэтэл энэхүү гэмт хэрэг, зөрчилд хүлээлгэх ял, шийтгэлийг хэрэгжүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх арга ажиллагаа орон нутагт төдийлөн үр дүнтэй байж чадахгүй байгааг анхаарах нь зүйтэй.

2. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, бусад асуудал

2.1 Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, статистик үзүүлэлт

2020 оны эхний 8 сарын байдлаар Ховд аймгийн Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 118 гомдол мэдээлэл хүлээн авчээ. Эдгээрээс 100 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 17, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдсэн байна. Энэ нь Ховд аймгийн хэмжээнд гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нийт дүн мэдээлэл болно.³

Гэр бүлийн хүчирхийллийн гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 2019 оны эхний 8 сарын байдлаар 49 байсан бол 2020 оны эхний 8 сарын байдлаар 118 болж, 66 гомдол мэдээллээр буюу 1.3 дахин өсжээ. Харин гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2019 оны эхний 8 сарын байдлаар 5 байсан бол 2020 оны эхний 8 сарын байдлаар 17 болон нэмэгдэж 12 хэргээр буюу 2.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийг насны байдлаар авч үзвэл, ихэнх нь 25-29 насныхан, боловсролын хувьд бүрэн дунд болон бүрэн бус дунд боловсролтой хүмүүс байна. Гэтэл гэр бүлийн хүчирхийллийн эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа энэ бүлэгт чиглээгүй болохыг өмнөх хэсэгт дурдсан билээ. Эдгээр хүмүүст хүрч ажиллах ёстой сум, багийн нийгмийн ажилтан, сумдын хамтарсан багийн ажил үйлчилгээ тэр бүр тэгш, хүртээмжтэй, өргөн цар хүрээг хамарч чадахгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай.


³ “Жендерийн тэгш байдлыг хангах” аймгийн дэд хөтөлбөр, түүний хэрэгжилтийн тайлан

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийг насны байдлаар болон үйлдэгдсэн цаг хугацаагаар нь авч үзвэл:

Насны байдлаар нь авч үзвэл: 16-24 насны 10; 25-29 насны 27; 30-34 насны 23, 35-39 насны 18, 40-44 насны 11, 45-49 насны 5, 50-54 насны 6, 55-59 насны 4, 60-67 насны 6 тус тус үйлдсэн байна.

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд 26, 14-19 цагийн хооронд 32, 19-22 цагийн хооронд 24, 22-06 цагийн хооронд 32 зөрчил тус тус үйлдэгдсэн байна.

Хүчирхийлэл үйлдэгчдийн боловсролын байдал:



Судалгаанд оролцогчдоос авсан асуумжийн үр дүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэхгүй байгаа шалтгааныг олж тогтоох зорилгоор дараах асуумжийг авч, тандалт хийв. Тухайн судалгаанд оролцогчдын хувьд эргэн тойронд нь буюу өөрт нь “гэр бүлийн хүчирхийлэл тохиолдоход цагдаагийн байгууллагад хандаж гомдол гаргадаг уу?”, “Хэрэв цагдаад мэдээлэл өгдөггүй бол яагаад” гэсэн асуултад нийт оролцогчдын 58 хувь нь “гомдол гаргадаггүй” гэсэн хариулт өгсөн бөгөөд үүнээс 24 хувь нь “цагдаад хандаад үр дүнгүй байдаг буюу асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлдэггүй”, 18 хувь нь “мөнгөн торгууль төлдөг учраас хүндрэлтэй байдаг” хэмээн хариулсан байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын гомдол шийдвэрлэж буй зарим албан хаагч гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхдээ жендерийн хэвшмэл ойлголтоор хандаж буйг тухайн салбарын зарим ажилтнаас авсан тандалт судалгааны үр дүн харуулж байв. Мөн цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй “Гэр бүлийн

хүчирхийлэлгүй баг, сум” шалгаруулах ажил нь зарим зөрчил, гэмт хэргийг нуун дарагдуулж, өөр заалтаар буюу Зөрчлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 1 буюу “Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах” заалтаар шийдвэрлэгдэж байх магадлалтай байна. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн 70 гаруй хувь нь гэр бүлийн хүрээнд архидан согтуурсан үед үйлдэгдэж байгаа бөгөөд үүнд хамаарах зарим гэмт хэрэг, зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 1 буюу “бусдын амгалан тайван байдал алдагдуулсан”, 15.9 дүгээр зүйлийн 1 буюу “худал дуудлага, мэдээлэл өгсөн” гэх заалтаар шийдвэрлэж байгааг тухайн салбарын мэргэжилтнүүдийн мэдээлэл, хохирогч эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс олж харлаа.

Зөрчлийн тухай хуулийн шийтгэл нь хүчирхийлэл үйлдэгчдэд нөлөөлж чадахгүй, үр дүн муутай буюу гэр бүлд нь эргээд сэтгэл санаа, эдийн засгийн дарамт учруулж байгааг анхаарч, өөр төрлийн шийтгэвэр, арга хэмжээ хэрэгтэй байгааг анхаарах шаардлагатай. Гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж байгаа “баривчлах” шийтгэл үр дүнгүй байдаг учир тухайн хохирогчид мэдүүлгээсээ буцах, торгуулийн дүн бага зөрчлөөр шийдүүлж, цаашид цагдаагийн байгууллагад гомдол мэдүүлэхгүй байх шийдэлд хүрч байгаа нь хүчирхийллийг даамжруулах эрсдэл дагуулж байна. Хэрэв торгуулийн шийтгэлийг хүчирхийлэл үйлдэгчээс өөрөөс нь гаргуулдаг байхаар зохицуулбал хохирогч давхар хохирохоос сэргийлж болох юм.

Асуулгад оролцсон гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зүгээс “Гэр бүлийн хүчирхийллийн цаад учир, холбогдлыг орхигдуулж зөвхөн эрчүүдэд бурууг өгөх хандлага их байдаг. Нэг ёсондоо гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль эмэгтэйчүүдэд илүү давамгайл байдал олгосон шинжтэй хууль болсон” гэж байв. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн гэр бүлийн гишүүд зан үйлд нөлөөлөх сургалтад хамтдаа хамрагддаг байх нь одоо явж байгаа хүчирхийлэгчийг албадан сургадаг сургалтаас илүү ач холбогдолтой болохыг онцолсон. Тиймээс эхнэр, нөхөр, хүүхэд зэрэг гэр бүлийн бүх гишүүний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон сэтгэл зүйн болон зан төлөвийн сургалт, нөлөөллийн ажил зайлшгүй шаардлагатай байна. Үүний тулд сургалт, нөлөөллийн ажил явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд ганцаарчилсан зөвлөгөө авах боломжоор хангах, багийн

нийгмийн ажилтнуудыг иргэдэд илүү ойр ажиллах боломжийг бүрдүүлэх, мэргэшүүлэх хэрэгтэй юм.

2.2 Холбогдох төрийн байгууллага буюу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаа

Тус байгууллага нь чиг үүргийн хувьд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хүрээнд дараах ажлыг голчлон хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, 2018 оны ажлын тайлангаас үзвэл “Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр хэрэгжүүлэх 24 дүрэм, журмыг хөтөлж хэвших арга зүйд 17 хамтарсан багийн гишүүд, 12 багийн нийгмийн ажилтныг сургаж, тогтмолжуулахаар аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллаж байна. Аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол мэдээлэл 125 бүртгэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн тоо 12, зөрчил 113, баривчлах арга хэмжээ авч саатуулагдсан 69 иргэн байна. Саатуулагдсан 69 иргэнд 28 удаагийн 48 цагийн сургалт хийж гэр бүлийн харилцаа, Монгол Улсын хууль тогтоомж ба хүүхэд хамгааллын талаар мэдлэг олгов. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж сэтгэл санаагаар хохирсон 10 хүүхэд байгаа бөгөөд 3-5 настай 3, 7-10 настай 3, 10-13 настай 3, 13-15 настай 1 хүүхэд гэсэн ангилалтай байна” гэжээ.

Мөн тус тайланд дурдсанаар аймгийн төвийн Жаргалант сумын 12 баг, хөдөөгийн 16 сумын давхардсан тоогоор 7500 иргэнд гэр бүлийн хүчирхийлэл, төрөөс гэр бүлийн талаар баримтлах бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар сурталчилж 2400 гаруй гарын авлага тарааж, хамтарсан багийн 108 гишүүнд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол бүрээр буюу 17 төрлөөр нөхцөл байдлын үнэлгээ хийх, хувийн хэргийн бүрдэлт хийх, холбон зуучилж ажиллах арга зүйд сургажээ. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн судалгааг сар бүр сумдын хамтарсан багаас авч нэгтгэдэг ажээ.

Харин 2019 оны эхний 10 сарын байдлаар ГБХЗХГ-т хүүхдийн тусламжийн 108 утсаар 45 дуудлага мэдээлэл, бичгээр 5 өргөдөл, нийт 50 өргөдөл, гомдол бүртгэгджээ. Нийт бүртгэгдсэн гомдол, мэдээллийн 25-30 хувь эрсдэл өндөр буюу хамгаалал шаардлагатай байгаа хэдий ч

стандартын хамгаалах байр байхгүйн улмаас 2 насанд хүрэгч, 6 хүүхдийг ажлын байр болон зочид буудалд байрлуулах замаар шаардлагатай хариу үйлчилгээг үзүүлж ажилласан байна. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг байрлах хугацаандаа амьдрах таатай орчныг бүрдүүлэх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөц болон шаардлагатай техник, тоног төхөөрөмж, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх шаардлагатай болох нь эндээс харагджээ.

ГБХЗХГ нь хохирогчдод “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-өөр дамжуулан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тус газрын дэргэдэх хүүхэд хөгжлийн дугуйлангууддаа үнэ төлбөргүй хамруулах арга хэмжээг авдаг ажээ. Харин одоогоор мэргэжлийн сэтгэл зүйчгүйн улмаас сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх боломжгүй болжээ.

Дээр дурдсан тоон мэдээлэл, үзүүлэлтээс харахад гэр бүлийн хүчирхийлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2020 онд 10-20 орчим хувиар өссөн байгаа бөгөөд үзүүлэх үйлчилгээ, туслалцааг хууль, журамд заасны дагуу үзүүлж байгаа ч гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах байргүйн улмаас эрсдэлийн түвшин улам бүр нэмэгдэж байгааг анхаарах шаардлагатай. Тодруулбал “гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг нөхцөл байдлаас нь хамаараад аюулын зэргээс нь шалтгаалан аль болох гэр бүлд нь буцаан нэгтгэх, гэр бүлийнх нь хэн нэгэн, ах дүү, хамаатан садных нь асрамжид шилжүүлэх зэрэг арга хэмжээг түлхүү авч байна” гэдгийг холбогдох мэргэжилтнүүд онцолж байна. Ингэж удаан хугацаагаар ажил үргэлжлэх нь цаашлаад олон эрсдэлийг дагуулах сөрөг нөлөөтэй тул хамгаалах байрны асуудлыг нэн даруй аймгийн хэмжээнд шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай юм. 2020 оны эхний хагас жилд хамгаалах байр ашиглалтад орох боломжтой байсан ч, стандарт шаардлага хангаагүй гэсэн шалтгаанаар ашиглалтад оролгүй хагас жил орчим хугацаа алдаж, судалгааны дүн эцэслэх үед буюу 2020 оны сүүлээр ашиглалтад орсон. Энэ асуудлыг хөндөж, анхнаасаа стандарт шаардлага хангаагүй шалтгааныг тогтоож, буруутай этгээдэд хариуцлага тооцох нь цаашид төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулахаас сэргийлэх ач холбогдолтой юм.⁴

⁴ Судалгааны дүн эцэслэгдэх үед буюу 2020 оны сүүлээр тус байр ашиглалтад орсон болно.

Тохиолдол 1: Ховд аймгийн Жаргалант сумын иргэн М, 30 настай, 4 хүүхэдтэй, тодорхой эрхэлсэн ажилгүй, мэргэжилгүй. Заримдаа зах дээр дэлгүүрт туслах хийдэг. Нөхөр байнга архи уудаг мөн тодорхой эрхэлсэн ажилгүй, мэргэжилгүй, үе үе барилгын туслах, мужааны туслах хийж амьжиргаандаа нэмэр болдог. Ихэвчлэн архи уусан үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг. Бидэнд өөрсдийн гэсэн гэр байхгүй, айлын гэрт амьдардаг. Манайх сургуулийн насны 2, цэцэрлэгийн насны 2 хүүхэдтэй. Нөхрөө зодож цохих үед нь Цагдаад дуудлага өгч баривчлуулж байсан боловч гарч ирээд улам бүр өсөрхөж дээрэлхдэг. Тиймээс дахиж Цагдаад дуудлага өгөхөө больсон. Архи уусан үед нь гэрээсээ гараад зугтдаг. Харин ГБХЗХГ-т хандаж учир явдлыг хэлж тухайн байгууллагын хүмүүс манай гэрт очиж нөхөрт хэлж ойлгуулсан үед нэг хэсэгтээ гайгүй байдаг. Тэгээд хэсэг хугацаа өнгөрсний дараа архиа уухаараа дахиад л асуудал давтагддаг” гэжээ.

Ийнхүү тус байгууллагын үйл ажиллагаанаас харахад иргэд рүү чиглэсэн зан үйлд нөлөөлөх арга ажиллагаа, нөлөөллийн ажлыг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа ч хүн хүч, нөөц боломж хомс байна. Хэдий дотоод нөөц хомсдолтой ч иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулах хүрээг өргөтгөх боломжтой.

2.3 Гэр бүлийн хүчирхийлэлд үзүүлэх хэвлэл мэдээлэл, олон нийт, нийгмийн сүлжээний нөлөө

Гэр бүлийн хүмүүжил төлөвшил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх төрлийн мэдээлэл түгээж буй эсэх болон гэр бүлийн хүчирхийлэлд үзүүлж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийн үр нөлөөг судлах зорилгоор үндэсний хэмжээний 10, орон нутгийн 2 телевизийн хөтөлбөрт мэдээллийн урсгалын дүн шинжилгээг хийв. Гэр бүлийн хөгжил, төлөвшил, дадал хэвшилд үзүүлж буй нөлөөлөл

бүхий нэвтрүүлэг контент бэлтгэн нэвтрүүлж буй эсэхийг 3 удаагийн давтамжтайгаар 7 хоног ажиглаж, 7 хоногийн нэвтрүүлгийн цагийг гэр бүлийн хөгжил, төлөвшил, дадал хэвшилд үзүүлж буй нөлөөлөл бүхий нэвтрүүлгийн цагтай харьцуулж хувиар илэрхийлэв.

Монголын Үндэсний олон нийтийн телевиз өдрийн эфирийн цагийн 7.6, Монгол HD ТВ 3.6, TV-9 телевиз 1.4, UBS-1 телевиз 1.4, ETV телевиз 1.4, MN25 телевиз 1.1, NTV 0.96, TV-5 0.96, Боловсрол телевиз 0.55, С1 телевиз 0.1 хувьд нь тус тус гэр бүлийн хөгжил, төлөвшил, дадал хэвшилд эерэг нөлөө үзүүлэх нэвтрүүлэг гарч байсан бол орон нутгийн томоохон телевизүүд болох Ховд телевиз, Олон ястны телевизээр зорилтот нэвтрүүлгийн цаг байхгүй байв. Энэ нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгэм рүү хандсан нэвтрүүлэг хийхгүй, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэхгүй байгааг харуулж байна.

Мөн хүүхдэд зориулсан нэвтрүүлэг контент ховор ч бүх суваг дээр тогтмол хүүхэлдэйн кино гарч байв. Энэ нь сайшаалтай ч зарим хүүхэлдэйн киноны үг хэллэг, утга агуулгад анхаарал хандуулах хэрэгтэй. Тухайлбал, хүүхдэд зориулсан боловч оновчгүй үг хэллэгтэй, хараалын үг хэрэглэсэн, буруу зүйлд өдөөн турхирсан, атаач сэтгэлгээг өдөөсөн агуулга бүхий хүүхдийн кино их байна. Түүнчлэн гаднын улс орны соёлыг хэт түгээх, эд материал, ахуйд шүтэх хандлага өгөхүйц агуулга бүхий хүүхэлдэйн кино түгээмэл үзүүлж байна. Хүүхдүүд гэр бүлийн гишүүдээс гадна үзэж буй кино контентоос үлгэр дуурайлал авдаг тул үүнийг анхаарах шаардлагатай.

Тиймээс цаашид хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн урсгал, нэвтрүүлгийн бодлогод анхаарах нь зүйтэй. Үүний тулд нийтлэл нэвтрүүлгийн бодлогод нөлөөлөх нь зүйтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусгай зөвшөөрлийн шалгуурт хувь хүний ухамсар сэтгэхүй, гэр бүл болон олон нийтийн эерэг хандлагыг бий болгох контентыг бэлтгэн түгээх шаардлага тавьж, хэрэгжилтэд хяналт тавих замаар нөлөөлөх боломжтой.

Асуулгад сургуулийн насны хүүхдүүд, насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэй болон Зөрчлийн хуулиар гэр бүлийн хүчирхийллийн улмаас баривчлах шийтгэл авсан хүмүүсийг оролцуулан хийсэн бөгөөд тэд гэр бүлийн хүчирхийллийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх боломж, хохирогч хаана, хэнд хандах гэх мэтчилэн иргэдэд хууль эрх

зүйн зөвлөн туслалцаа авах арга зам нөхцөлийн талаарх мэдээллийг ихэвчлэн нийгмийн сүлжээнээс авч байна. Хүчирхийллийг мэдээлэх, таслан зогсоохтой холбоотой мэдлэг мэдээллийг иргэд цаг хугацаа орон зайнаас үл хамааран авахын зэрэгцээ сэтгэл гутрал, хүчирхийллийг даван туулж буй нөхцөл байдлаа нийгмийн сүлжээ ашиглан бусадтай хуваалцаж, зөвлөн туслах үйлчилгээ авах боломж бүрдсэн нь мөн ололттой.

Тохиолдол 2: “Гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртдөг 28 настай, 2 хүүхэдтэй эмэгтэй өөрт тохиолддог асуудлаа шийдвэрлэхийн тулд сэтгэл зүйчтэй цахимаар холбогдож гэр бүлийн харилцааны талаарх хандлага төлөвшилөө өөрчилж, хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд өөрөөс шалтгаалах зүйлсийг мэдэж авч байгаадаа талархаж байна” хэмээн тэрээр цахим орчинд сэтгэгдлээ үлдээсэн байв.

Гэвч хүчирхийлэгчид сэдэл өгөх, сэтгэл санааг нь тавгүйтүүлэх, бусдыг аялдан дагалдах, цахим орчны сөрөг уур амьсгалд хэт автах, цахим тоглоом, хэрэглээнд донтох зэрэг сөрөг үр дагаврыг ч нийгмийн сүлжээ дагуулж байгааг анхаарахгүй байхын аргагүй. Сүүлийн жилүүдэд цахим орчин хувь хүн төдийгүй, нийгмийг ч залан чиглүүлэхэд жинтэй нөлөө үзүүлж буй билээ. Иймд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нөлөөллийн ажил, зарим үйл ажиллагааг иргэдийн цахим орчны хэрэглээнд тулгуурлан явуулбал зорилтот хүмүүст хүрэх нэг арга зам байх боломжтой. Мөн иргэд бие биеэсээ мэдээлэл авах, харилцан санал солилцох үедээ ч мэдлэг авч байдаг тул найз нөхөд, хөршийн холбоо, эцэг эхийн зөвлөлийг чадавхжуулах чиглэлээр ч үр дүнтэй ажиллах хэрэгцээ байна.

3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Гэр бүлийн хүчирхийллийг зөрчил, гэмт хэрэгт тооцон хуульчилж, зөрчил үйлдвэл Зөрчлийн тухай хуулиар 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулж, зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах, харин гэмт хэрэг үйлдвэл зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл мөн хугацаагаар хорих ял ногдуулах болон мөнгөн торгууль ногдуулахаар зохицуулсан. Мөн заналхийлэх, мөрдөн мөшгөх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон ч энэ заалтын хүрээнд Ховд аймгийн хэмжээнд шийдвэрлэгдсэн гэмт хэрэг болон, гаргасан гомдол одоогоор байхгүй байна. Үүний зэрэгцээ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндвэл ял шийтгэлийг хүндрүүлж авч үзэхээр Эрүүгийн хуульд тусгасан. Энэ төрлийн гэмт хэрэг аймгийн хэмжээнд 1 үйлдэгдэж түүнд мөнгөн торгууль ногдуулж, улмаар гэр бүл нь хуулийн дагуу гэрлэлтээ цуцалж хэргийг шийдвэрлэжээ.

Ховд аймгийн Шүүхийн тамгын газраас Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой Эрүүгийн тухай хуулиар шийдвэрлэж байгаа хэргүүдийн ихэнх нь Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.2, 11.7 дахь заалтын хүрээнд шийдвэрлэгдсэн байна. Тоон үзүүлэлтийг авч үзвэл тус шүүхээс 2017 онд 11.6.2-оор 1, 2018 онд 11.7.1-ээр 1, 11.6.2-оор 7, 2019 онд 11.7.1-ээр 1, 11.6.2-оор 10 гэмт хэрэг тус тус шийдвэрлэжээ. Эндээс ихэнх холбогдогчид мөнгөн торгууль ногдуулах нь түгээмэл байгааг харж болно. Учир нь Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.2-т зааснаар “Энэ гэмт хэргийг энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэсэн байдаг. Шүүгчдээс ихэвчлэн уг заалтыг хэрэглэж буй шалтгаан нөхцөлийг тодруулахад “ихэнх хэргийн хохирогч, шүүгдэгч

нар шүүхэд ирэх хугацаанд хоорондоо эвлэрч, тохиролцож, мөнгөн торгууль төлж уг асуудлыг дуусгахыг хүсдэг тул энэ зүйл заалтыг хуулийн хүрээнд хэрэглэдэг” гэж байв. Гэхдээ цаашид гарах үр дагавар, шалтгаан нөхцөлийг авч үзвэл, хүчирхийлэл үйлдэгчийг зөвхөн мөнгөн торгууль ногдуулаад гэм бурууг нь ухамсарлуулна гэвэл өрөөсгөл юм. Тиймээс үүнд тохирсон өөр төрлийн арга хэмжээг давхар авдаг байх шаардлагатай.

Мөн Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийн зарим хэлбэр болох “сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл” гэсэн хоёр төрлийн хүчирхийллийг хэрхэн яаж шийдвэрлэх, түүнд ямар арга хэмжээ авах тухай тодорхой тусгаагүй байгааг анхаарах нь зүйтэй. Шүүгчдэд уг хуулийг хэрэглэх тайлбарт “гэр бүлийн хүчирхийлэл гэдгийг бие махбодын хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл гэж цогц утгаар нь авч үзнэ” хэмээн тайлбарласан хэдий ч Эрүүгийн хуульд бусад хоёр төрлөөс нь ялгаж оруулаагүй. Гэтэл гэр бүлийн хүчирхийллийн далд хэлбэр их байгаа гэх судалгааны дүнгээс харахад ихэнх нь энэ хоёр төрлийн хүчирхийлэл байдаг байна.

Судалгаанд хамрагдсан шүүгчдийн онцолж буйгаар “иргэд нэг үеэ бодвол гэр бүлийн хүчирхийлэл ялган таньж, тэвчиж болохгүй зүйл гэдгийг мэддэг болсон. Түүнээс улбаалаад зарим тохиолдолд энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа нь үүнтэй холбоотой. Мөн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг харж байхад дийлэнх нь ажилгүйдэл, стресс бухимдлаас үүссэн асуудлууд байдаг” гэж онцолж байв. Тиймээс шалтгаан нөхцөл, тулгарсан асуудалтай нь уялдуулан ял шийтгэл оногдуулж байвал үр дүнтэй. Тухайлбал, нийтэд тустай ажил хийлгэх, уур бухимдлаа тайлж сургах, сэтгэл зүйн дэмжлэг нөлөөлөл үзүүлэх арга хэрэгслийг эвлэрсэн, хохирогч мэдүүлгээсээ буцсан нөхцөлд хэрэглэдэг байж болох юм. Энэ нь хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга зам болно.

Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдэж байгаа гэмт хэргийн дийлэнх нь өмнө нь зөрчлийн хуулиар шийтгэгдэж байсан, эсвэл гэр бүлийн гишүүний биед хүндэвтэр гэмтэл учруулсан нөхцөлүүдтэй хэргүүд ирдэг байна. Харин энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн холбогдогчдод оногдуулж байгаа ял шийтгэл нь дээр дурдсанчлан ихэнхдээ мөнгөн

торгууль ногдуулах байдлаар шийдэгджээ. Эдгээр гэр бүлийн дийлэнх нь гэр бүлээ цуцлуулахгүй буцаад хамт амьдардаг учраас эдийн засгийн аргаар шийтгэлийг оногдуулах нь өрөөсгөл юм. Энэ нь тухайн гэр бүлд эдийн засгийн хийгээд, сэтгэл санааны дарамт, хүчирхийллийг давхар үүрүүлэх магадлалтай. Харин Зөрчлийн тухай хуулийн нэг адил зан үйлд нөлөөлөх сургалт, соён гэгээрүүлэх арга хэлбэрийг хамтатган хэрэгжүүлдэг байвал үр дүнтэй. Үүний тулд боловсон хүчин, материаллаг бааз суурийг давхар бэхжүүлэх шаардлагатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүчирхийлэл үйлдэгчийг хохирогчийн ажиллаж, амьдардаг газар очих, уулзахыг хориглох, тодорхой газраар зорчихыг хориглох хязгаарлалтын арга хэмжээ авах боломжтой болсон. Энэ заалтыг Ховд аймгийн хэмжээнд эрүүгийн 1 хэрэг дээр хэрэглэсэн бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг 6 сарын хугацаанд гэр бүлийн хамаарал бүхий хүмүүс болох эхнэр, хүүхэдтэй нь уулзах эрхийг хязгаарлаж байжээ.

Энэ асуудлын хүрээнд ярилцлагын хэлбэрээр дэлгэрүүлэн асууж ярилцахад ихэнх гэр бүлийн хүчирхийллийн эхний шинж тэмдэг бүхий дуудлагыг архи согтууруулах ундаа хэрэглэсэн хүмүүсийн ар гэрээс өгдөг. Ихэвчлэн бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан гэсэн зөрчлөөр 100 нэгж буюу 100,000 төгрөгөөр торгож, эрүүлжүүлэх байранд саатуулаад гаргадаг ажээ. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх эрх зүйн орчны хүрээнд үүнээс өөрөөр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэлбэр байхгүй байгаа нь асуудал даамжрахад хүргэж байна. Тухайлбал, архи согтууруулах ундаа байнга хэрэглэдэг, энэ үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг асуудлаар цагдаагийн газарт ирсэн ихэнх дуудлага, гомдол нь Зөрчлийн тухай хуулийн “бусдын амгалан тайван байдал алдагдуулсан” гэх зүйл заалтаар шийдвэрлэгддэг тул хохирогчдоод өөрсдийг нь хамгаалах өөр арга механизм байхгүй гэх хандлага, ойлголтыг өгдөг ажээ. Гэтэл цагдаагийн газарт ирж байгаа бусдын амгалан тайван байдал алдагдуулсан гэх дуудлага мэдээллийг ангилан үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл байж болохуйц шинж тэмдэгтэй дуудлага, гомдол бүртгэгдсэн байх нь бий. Үүнийг хохирогч эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлага ч баталж байгаа юм. Тиймээс хүчирхийлэл хөнгөн хэлбэртэй илэрч байгаа энэ үед мөнгөн торгууль, баривчлах шийтгэл оногдуулах бус, харин соён гэгээрүүлэх, ухамсар

сэтгэхүйд нь нөлөөлөх ажлыг хөндлөнгийн байгууллага зохион байгуулдаг байх нь илүү үр дүнтэй юм.

Тэгэхээр Цагдаагийн газар ирж байгаа гэр бүлийн хүрээнд архидан согтуурсан, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан гэх гомдол мэдээллийг шинжлэн үзэж, гэр бүлийн хүчирхийллийн шинж тэмдэг байгаа эсэхийг харгалзан, давхар хөршийн хяналтын хүрээнд мэдээлэл цуглуулах замаар дээр дурдсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэлбэрийг ашигладаг байвал тухайн хохирогч, холбогдогчдод илүү үр өгөөжтэй. Харин энэ төрлийн зөрчлийг “Зөрчлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.5.1-ийн дагуу нэг зуун нэгж буюу 100,000 төгрөгөөр торгож байгаа нь тухайн гэр бүлийн зөрчил даамжрахын зэрэгцээ, эдийн засгийн хувьд давхар хохирох эрсдэлийг дагуулж байна. Үүний улмаас аль болох цагдаад дуудлага өгөхгүйг хичээж, хүчирхийллийг тэвчин өнгөрүүлж байгаа нь асуудлыг улам даамжруулж байгаа болохыг асуулга, ярилцлагад оролцогчид илэрхийлж байсан.

Тухайн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан нөхцөлөөр шийтгүүлэхээргүй буюу эрт шатандаа байх тохиолдолд хөнгөн хариуцлага оногдуулах зохицуулалтыг нэмж тусгах хэрэгцээ байна. Энэ хүрээнд зан үйлд нөлөөлөх сургалтад суулгахыг даалгах, сануулах гэх мэт байж болох юм. Мөн зан үйлд нөлөөлөх сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх ажил зохион байгуулахгүй бол өнөөгийн хэрэгжүүлж буй арга зам үр дүнгүй байна. Тухайлбал, Ховд аймгийн Цагдаагийн газрын дэргэдэх баривчлах байранд баривчлагдаад гарсан хүмүүсээс авсан асуумж, ярилцлагын үр дүнгээс харахад тэдгээр хүмүүс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаар тодорхой хэмжээний мэдлэг, мэдээлэлтэй байгаа хэдий ч зан төлөвшлийн хувьд бусдад хүч хэрэглэж болохгүй гэдэг хандлага, ойлголт суугаагүй болох нь ихэнх хүмүүсээс харагдаж байв. Түүнчлэн баривчлах шийтгэл эдлэх хугацаандаа Цагдаагийн газрын ажилтнуудын нөөц боломжийн хүрээнд үзүүлж байгаа “Хуулийн талаарх мэдлэг өгөх сургалт”, “архины хор уршгийн талаарх сургалт”-уудад ихэвчлэн хамрагдсан байна. Харин сэтгэл зүй, зан үйлд нөлөөлөх сургалт ороогүйг онцолж байв. Мөн Цагдаагийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бүртгэлтэй гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 48 хүний бүртгэл мэдээлэлтэй танилцахад 1 хүн л Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагджээ.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 15.9.1-д заасан зарим дуудлага мэдээллийг нягталбал гэр бүлийн маргаан байж болзошгүй байна. Гэтэл гэр бүлийн хүрээнд үүссэн маргаанаас үүдсэн гэр бүлийн зөрчлийн шинжтэй үйлдлүүдэд “гэмт хэрэг, зөрчлийн талаар худал дуудлага өгсөн” гэх зүйлээр шийтгэх тохиолдол гарч байгаа бөгөөд энэ нь торгуулийн хэмжээ бага байдагтай холбоотой ажээ. Торгуулийн дүнгээс шалтгаалан хоорондоо тохиролцож энэ арга замыг сонгодог байж болох юм. Нөгөө талаас, шүүхээр шийдвэрлэгдэж буй ихэнх зөрчил, гэмт хэрэгт хохирогч, холбогдогч хоорондоо эвлэрсэн байгаагаас үзэхэд цагдаагийн байгууллагад дуудлага өгөх шатанд ч мөн адил байхыг үгүйсгэхгүй.

Шүүхээс баривчлах шийтгэл оногдуулахдаа тодорхой цагийн Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад суухыг даалгаж байгаа ч өнөөгийн байдлаар Ховд аймагт энэ сургалтыг хийх мэргэшсэн байгууллага байхгүй байна. Эндээс зан үйлд нөлөөлөх сургалт явуулах хуулийн заалт хэрэгжихгүй байгааг харж болно. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Цагдаагийн газраас тухайн байгууллагын ажилтан, алба хаагчид хийж байгаа нь мэргэжил арга зүйн хувьд үр дүнгүй, оновчтой сэдвээр явагддаггүйг фокус бүлгийн ярилцлага, уулзалтад оролцогчид онцолж байв. Учир нь Цагдаагийн байгууллагын ажилтнууд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, холбогдогчдын зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах чиглэлээр бэлтгэгдээгүйтэй холбоотой. Түүнчлэн Цагдаагийн газрын Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын сэдэв, хөтөлбөрөөс харахад ихэвчлэн хууль, дүрмийн талаарх мэдлэг, архи тамхины хэрэглээ буюу хорт зуршлын сөрөг үр дагаврын талаар сургалт зонхилж байна. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх хэрэгцээ байгааг холбогдох албаныхан онцолдог ч энэ чиглэлээр санаачилга гаргахгүй явж иржээ.

ДҮГНЭЛТ

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудалд хариу арга хэмжээ үзүүлэх ёстой холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангаж ажиллахгүй байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Нэн ялангуяа урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зорилтот бүлэгтээ хүртээмжтэй хүрэхгүй байгаа нь судалгааны дүнгээс харагдсан. Тиймээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг хүргэж буй хүмүүсийн боловсрол, насны байдлыг эргэн харж хүчирхийлэл үйлдэгдэж буй зонхилох бүлэг рүү үйлчилгээгээ чиглүүлэх шаардлагатай.
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах, олон нийтийн хандлагыг өөрчлөх, мэргэжилтнүүдийг сургах, чадавхжуулах, хохирогчид үзүүлэх үйлчилгээний чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаа орон нутагт сул, уялдаа холбоо муутай байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн цагдаа, эмч, багш, нийгмийн ажилтан зэрэг мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг нэгдсэн хөтөлбөр, агуулгаар, тодорхой давтамжтай явуулахгүй байгаагаас мэргэжилтнүүд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдолд үр дүнтэй хариу үйлдэл үзүүлж чадахгүй байна. Мөн тэднийг тогтвортой ажиллах нөхцөлийг нь хангах, орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага ч байна.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцахаар заасан боловч орон нутагт сургалт явуулах мэргэжлийн багш, хэрэглэгдэхүүн, багш нарт олгох зардал шийдэгдээгүй байна. Мөн эдгээр ажилтны хандлага, мэргэжлийн онцлог Зан үйлд нөлөөлөх сургалтыг явуулахад учир дутагдалтай байгааг судалгаанд оролцогчид

онцолсон.

- Баривчлах ял шийтгэл авсан хүмүүст оногдуулдаг “Зан үйлд нөлөөлөх албадан сургалт”-ыг хууль журмын дагуу бүрэн өгөхгүй байна. Мөн тухайн гэр бүл хуулиар гэрлэлтээ цуцлуулаагүй бол гэр бүлийн гишүүдийг нь давхар зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах шаардлагатай байна.
- Түүнчлэн энэ төрлийн сургалтыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлж болно гэж заасан боловч орон нутагт тэр бүр мэргэшсэн, чадавхтай төрийн бус байгууллагууд олноор байхгүй байгаа учраас бодлогоор дэмжиж сургаж, чадавхжуулах эрэлт хэрэгцээ байна.
- Боловсролын байгууллагуудын чиг үүрэг болон боловсролын сургалтын системд гэр бүлийн боловсрол, хүмүүжлийг хувь хүний хөгжил төлөвшилтэй уялдуулж өгөх хэрэгтэй юм гэдгийг судалгааны явцад ажиглалаа.
- Нийгмийг дагуулагч чиг шугам буюу олон нийтийн санаа бодлыг чиглүүлэгч болж байдаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн контентуудад гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх агуулгатай контентуудыг бодлогоор түгээхийг чухалчлах хэрэгтэй байна.
- Зөрчлийн тухай хуулийг ялгамжтай байдлаар ашиглаж гэмт хэрэг, зөрчлийг нуун дарагдуулж буй явдал ажиглагдаж байна. Тухайлбал, архи согтууруулах ундаа хэрэглэдэг, хэрэглэсэн үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг хүмүүсийн нөхцөл байдлаас харахад Цагдаагийн газарт ирсэн зарим дуудлага, гомдлууд нь “бусдын амгалан тайван байдал алдагдуулсан” буюу энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1-ээр шийдвэрлэж буй нь хохирогчдод өөрсдийг нь хамгаалах өөр арга механизм байхгүй гэх хандлага, ойлголтыг төрүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, хүчирхийлэл хөнгөн хэлбэртэйгээр илэрч байгаа үед урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөвхөн мөнгөн торгууль, баривчилж шийтгэх байдлаар бус соён гэгээрүүлэх, ухамсар сэтгэхүйд нь нөлөөлөх ажлыг давхар хийх нь үр дүнтэй гэж судалгаанд оролцогчид онцолсон.
- Эрүүгийн хуулиар шийдвэрлэгдэж байгаа гэмт хэргүүдийн

дийлэнх нь өмнө нь Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдэж байсан, эсвэл гэр бүлийн гишүүний биед хүндэвтэр гэмтэл учруулсан нөхцөлүүдтэй хэргүүд ирдэг байна. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн холбогдогчдод оногдуулж байгаа ял шийтгэл нь ихэнхдээ мөнгөн торгууль ногдуулах байдлаар шийдэгдсэн байна. Тухайлбал, 11 дүгээр зүйлийн 11.6.2 дахь заалтаар мөнгөн торгууль оногдуулж шийдвэрлэж иржээ. Гэтэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид болон хохирогчдын бодит нөхцөл байдал мөнгөн торгууль төлснөөр шийдвэрлэгдэх асуудал биш. Мөн эдгээр гэр бүлүүдийн дийлэнх хэсэг нь гэр бүлээ цуцлуулахгүй буцаад хамт амьдардаг учраас эдийн засгийн аргаар шийтгэлийг оногдуулах нь өрөөсгөл юм. Энэ нь тухайн гэр бүлд эдийн засгийн хийгээд сэтгэл санааны дарамт, хүчирхийллийг давхар үүрүүлэх магадлалтай. Харин Зөрчлийн тухай хуулийн нэг адил “Зан үйлд нөлөөлөх сургалт”-ыг хавсран хэрэглэвэл үр дүнтэй гэж үзэж байна. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэх боловсон хүчин, мэргэжилтнүүдийн бааз суурийг давхар бэхжүүлэх нь зүйтэй.

- Эрүүгийн хуулийн 11.6, 11.7-ын хоорондох адил төстэй зүйлчлэлийг ерөнхий утгаар нь хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэдгээр нь авч үзэж ял, шийтгэл оногдуулж байгаа хэлбэр нь хуулийг ашиглахдаа алдаатай буюу буруу ял шийтгэл оногдуулж байх магадлалтай. Учир нь энэ хуулийн 11.6-д хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэдэг нь ерөнхий утгаараа буюу гэр бүлийн гишүүдээс бусад хүнд хамаарах зүйл гэж харагдаж байна. Харин 11.7-д тодотгоод гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт “хорих болон, зорчих эрхийг хязгаарлана” гэж заасан байтал хөнгөвчилсөн байдлаар мөнгөн торгууль ногдуулах хэлбэрийг дийлэнхдээ сонгож ял, шийтгэл оногдуулж иржээ. Тиймээс энэ тохиолдлуудад уг ял, шийтгэлийн зүйлчлэлийг эргэн харах шаардлага байгааг илтгэж байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн төрөл болох сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл нийгэмд өргөн байгаа ч түүнд тохирсон ял шийтгэл, арга ажиллагаа байхгүйг эрх зүйн орчинд тусгах хэрэгцээ байна. Энэ нь хүчирхийллийг бага түвшинд нь илрүүлж, тохирсон арга хэмжээг авахад чухал

нөлөөтэй. Мөн хууль тогтоомжоор сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоох боломжгүй байгаа нь үүнд нөлөөлж байж болох юм.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Төрөөс хэрэгжүүлж буй ажлуудын цар хүрээг өргөтгөж, зорилтот бүлэгт чиглүүлэхэд анхаарах.
2. Гэр бүлийн хүчирхийлэлд оногдуулж буй ял, шийтгэлийг хэрэгжүүлж буй цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудын хандлага, ур чадвар, ёс зүй, жендерийн мэдрэмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд анхаарах, шаардлагатай бусад нөөцөөр хангах.
3. Прокурорын байгууллагын хяналтыг сайжруулах буюу шийдвэрлэгдэж буй гэмт хэрэг, зөрчилд оногдуулж буй ял шийтгэлийн хэрэгжилтийг хангахад анхаарах.
4. Зан үйлд нөлөөлөх сургалтыг зөвхөн хүчирхийлэл үйлдэгч буюу холбогдогчдод хийх бус хохирогч, гэр бүлийн бусад гишүүнийг хамруулж хийхэд анхаарах.
5. Хуулийг ялгамжтай байдлаар хэрэглэж гэр бүлийн хүчирхийллийг даамжруулж буй нөхцөл байдлыг анхаарч үзэх.
6. Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тодорхой ажлыг зохион байгуулахдаа гэмт хэрэг, зөрчлийг нуун далдлах байдалд хүргэхгүй байхад анхаарах. Үүний тулд шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох, тухайлбал гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлт буурсан гэхээс илүүтэй гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийг илрүүлж, түүнд тохирсон хариу арга хэмжээ авч, эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байдлыг үнэлэх гэх мэт.

НОМ ЗҮЙ

1. Ховд аймгийн Шүүхийн тамгын газрын 2018, 2019, 2020 онуудын 1-3-р улирлын статистик мэдээлэл
2. Ховд аймгийн Цагдаагийн газрын 2018, 2019, 2020 онуудын Гэмт хэргийн гаралт болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тухай мэдээлэл, тайлан
3. Ховд аймгийн Цагдаагийн газрын түр саатуулах байрны сургалт, хүмүүжлийн төлөвлөгөө
4. Ховд аймгийн ГБХЗХГ-ын Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтний 2018, 2019, 2020 онуудын ажлын тайлан, Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн судалгаа, мэдээлэл
5. Ховд аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн түүний Гэр бүлийн асуудалтай холбоотой аймаг орон нутгаас хийж хэрэгжүүлж буй ажлын тайлан мэдээлэл, бодлогын бичиг баримтууд буюу Ховд аймагт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүд болон түүний тайлангууд
6. Ховд аймгийн БСУГ-ын Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын тайлан
7. Ховд аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУССЗ-ийн 2020 оны ажлын төлөвлөгөө, тайлан мэдээлэл
8. Зөрчлийн тухай хууль
9. Эрүүгийн хууль
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
11. Жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2017
12. Үндэсний статистикийн хорооноос 2017 онд хийсэн ”Монголын эмэгтэйчүүдийн амьдралын туршлага”-ын судалгаа
<http://legalinfo.mn/>
<http://www.court.kho.gov.mn/>

ХАВСРАЛТ.


ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААР ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН

Нэг. Сургуулийн насны хүүхдүүдээс авсан судалгаа


Энэхүү судалгааг Ховд аймгийн Жаргалант сумын Цаст алтай цогцолбор сургууль (аймгийн төв хэсэгт байрлах сургууль), Жаргалант сумын 7-р сургууль (Гэр хорооллын хэсэгт байрлах сургууль)-аас түүвэрлэн авлаа. Мөн 7-р сургуулийн дотуур байрны хүүхдүүдийг хамруулав.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд дараах байдлаар хариулсан байна (100 хүүхэд судалгаанд хамрагдав).

1. Таны гэр бүл болон ойр тойрны таньдаг хүмүүсийн хүрээлэлд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан хүн бий юу?




2. Та гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан уу?




Хоёр. Насанд хүрэгчид буюу эмэгтэйчүүдийн төлөөллөөс авсан судалгаа

1. Таны гэр бүл болон ойр тойрны таньдаг хүмүүсийн хүрээлэлд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан хүн бий юу? (100 хүн хамрагдав.)



Харин тухайн хүнийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг судлахад дараах байдлаар хариулсан байна.


2. Та гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан уу?



Гурав. Насанд хүрэгчид буюу эрэгтэйчүүдээс авсан судалгааны дүн


Эрэгтэйчүүдээс авсан судалгааны дүнгээс үзэхэд тэд ингэж хариулжээ. Судалгаанд нийт 50 хүн хамрууллаа.

1. Таны гэр бүл болон ойр тойрны таньдаг хүмүүсийн хүрээлэлд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан хүн бий юу?



Эрэгтэйчүүдийн хариулсан байдлыг дараах графикаас харна уу.

2. Та гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан уу?



Дөрөв. Цагдаагийн газрын дэргэдэх баривчлах байранд “Баривчлах” шийтгэл хүлээсэн холбогдогчдоос авсан судалгаа


Баривчлах байранд 7-30 хоногийн баривчлах шийтгэл авсан хүмүүсээс авсан судалгаанаас үзэхэд ихэнх гэр бүлийн хүчирхийллийн шалтгааны нэгдүгээрт буюу 67 хувь нь үл ойлголцол, 2-рт архи согтууруулах ундаанаас үүддэг гэж хариулсан байна. Энэ асуумжаас харахад гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад хүмүүс хоорондын харилцаа хандлага хийгээд архины хэрэглээг багасгах зайлшгүй шаардлагатай байгааг харж болно.

1. Та гэр бүлийн хүчирхийллийн шалтгааныг юу гэж үзэж байна вэ?




Дараагийн асуумжаас үзэхэд архи согтууруулах ундаанаас хол байх нь гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох гол үндэс болно гэж дийлэнх нь хариулжээ.

2. Гэр бүлийн хүчирхийллээс ангид байхын тулд та юу хийх вэ?




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас оногдуулж байгаа одоогийн ял, шийтгэлийн хувьд дийлэнх нь буюу 43 хувь нь сайжруулах шаардлагатай гэж хариулжээ. Мөн ярилцлагын аргаар авсан асуумжтай харьцуулахад энэхүү хариулт нь хуулийг хэрэгжүүлэх шатанд хэрэгжилт, үр дүн муу байгааг онцолсон. Тиймээс баривчлах шийтгэл авсан хүмүүст оногдуулдаг “Зан үйлд нөлөөлөх албадан сургалт”-ыг хууль журмын дагуу бүрэн өгөхгүй байгааг онцолж байсан.

3. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас оногдуулж байгаа энэхүү шийтгэл нь та бүхний гэр бүлийн маргаан зөрчлийг арилгаж, засрахад үр дүн өгч байна уу?



Тухайн гэр бүлд үүсдэг ихэнх зөрчил маргааны гол шалтгаан нь архины хэрэглээ байдаг гэж 78 хувь нь хариулжээ. Гэтэл дээрх 1-р асуумж бүхий графикт харуулснаар гэр бүлийн хүчирхийлэл үүсэх эхний шалтгаан бол “үл ойлголцол” гэсэн. Үүнийг тодруулбал, үл ойлголцлын улмаас архи согтууруулах ундаа хэрэглэх явдал их байдгийг оролцогчид онцолсон.

4. Танай гэр бүлд үүсдэг ихэнх маргааны гол шалтгаан нь юу байдаг вэ?



Тухайн холбогдогч гэм буруугаа хүлээн зөвшөөрч, ойлгоод гарч болох ч хүрээлэн байгаа гэр бүлийн гишүүдийн хандлага, зан үйл өөрчлөгдөөгүй байх нь гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлдөг тул зан үйлд нөлөөлөх сургалтад хамтдаа хамрагдах нь үр дүнтэй гэж тэд үзсэн.

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН СУДЛААЧИД ДҮГНЭСЭН НЬ